

**ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ЭД ЭРХТЭН,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУУЛЬ БУС ХУДАЛДАА, АГНУУРТАЙ
ХОЛБООТОЙ ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Зохион байгуулсан:



Захиалж, санхүүжүүлсэн:



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ САН

Гүйцэтгэсэн:



ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛЬ

Хамтран ажилласан:



БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОРЫН
ГАЗАР



ХИЛ ХАМГААЛАХ
ЕРӨНХИЙ ГАЗАР



ЦАГДААГИЙН
ЕРӨНХИЙ
ГАЗАР



ГААЛИЙН
ЕРӨНХИЙ
ГАЗАР



МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Хянаж, редакторласан:

Л.Нямгэрэл

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга

Гүйцэтгэсэн:

Ч.Нямсүрэн

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн зөвлөх профессор, хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Д.Бадамцэцэг

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч

Зөвлөх:

Б.Чимэддорж

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын байгаль хамгааллын асуудал хариуцсан захирал

С.Пүрэвсүрэн

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын хууль бус агнуур, худалдааны асуудал хариуцсан зөвлөх

М.Эрдэнэбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Гэмт хэрэг илрүүлэхүйн профессорын судалгааны багийн профессор, цагдаагийн хурандаа, хууль зүйн ухааны доктор (Ph.D)

М.Отгонжаргал

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны шинжээч бөгөөд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

ГАРЧИГ

| | |
|-------------------------|----|
| ӨМНӨХ ҮГ | 6 |
| УДИРТГАЛ | 8 |
| ТОВЧИЛСОН ҮГС | 10 |
| ТАЛАРХАЛ | 11 |

| | |
|---|-----------|
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ, ТҮҮНИЙ ДОТОР ХУУЛЬ БУСААР АН АГНАХ, БАЙГАЛИЙН УРГАМАЛ ТҮҮЖ, БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ | 13 |
| 1.1. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн өнөөгийн байдал | 14 |
| 1.2. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн улмаас учруулсан хохирол | 19 |
| 1.3. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж | 21 |

| | |
|---|-----------|
| ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР, ТЭДГЭЭРИЙН АГУУЛГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ | 31 |
| 2.1. Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн агуулга | 32 |
| 2.2. Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээр | 37 |
| 2.3. Монгол Улсын Засгийн газрын тогтоол | 42 |

| | |
|--|-----------|
| ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС, ОХУ, БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ТЭДГЭЭРИЙН ХАРЬЯА ЯАМ, АГЕНТЛАГУУДЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ, ЯЛАНГУЯА ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУУЛЬ БУС ХУДАЛДАА, АГНУУРТАЙ ХОЛБООТОЙ ЗҮЙЛ, ЗААЛТУУД ТУСГАГДСАН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭРИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ | 45 |
|--|-----------|

| | |
|--|--------------|
| 3.1. Зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах талаар Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар болон яам, агентлагуудын хооронд байгуулсан хоёр талт гэрээ хэлэлцээр, актад хийсэн шинжилгээ | . 48 |
| 3.2. Зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах талаар Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар болон яам, агентлагуудын хооронд байгуулсан хоёр талт гэрээ хэлэлцээр, актад хийсэн шинжилгээ | . 56 |
| ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ | 65 |
| АШИГЛАСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, АЖЛЫН ТАЙЛАН | 73 |
| ХАВСРАЛТ. БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ 1990 ОНЫ 5 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДРИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛ (Төсөл). | 75 |

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|--------------|
| Зураг 1. Байгаль хамгаалах журмын эсрэг болон хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн байдал (улс, нийслэл, орон нутгаар, 2013-2017 он, 2018.I-VIII сар). | 14 |
| Зураг 2. Байгаль хамгаалах журмын эсрэг болон Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (нийслэл, бүсээр, 2013-2017 он, 2018.I-VIII сар) | 15 |
| Зураг 3. Байгаль хамгаалах журмын эсрэг болон хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (аймаг, дүүргээр, 2013-2017 он, 2018.I-VIII сар). | 15 |
| Зураг 4. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт (сая.төгрөг). | 19 |

| | |
|---|----|
| Зураг 5. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжууд, тэдгээрийн дотор хүрээлэн буй орчин болон амьтан, ургамалтай холбогдох хууль | 32 |
| Зураг 6. Монгол Улсын нэгдэн орсон олон талт болон хоёр талт олон улсын гэрээ, конвенц (хувиар) | 40 |
| Хүснэгт 1. Эрүүгийн хууль (2002 он) дахь Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн үйлдэгдсэн байдлыг зүйл бүрээр нь харуулбал | 16 |
| Хүснэгт 2. Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) дахь Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн үйлдэгдсэн байдлыг зүйл бүрээр нь харуулбал | 17 |
| Хүснэгт 3. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн байдал (сая.төгрөг) | 20 |
| Хүснэгт 4. Монгол Улсын хууль тогтоомжууд дахь амьтан, ургамалтай холбоотой эрх зүйн зохицуулалтууд | 34 |
| Хүснэгт 5. Монгол Улсын нэгдэн орсон олон талт конвенц, протокол | 37 |
| Хүснэгт 6. Монгол Улсын бусад улс орнуудтай байгуулсан хоёр талт хэлэлцээр | 40 |
| Хүснэгт 7. Хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг байгуулж, хамтын ажиллагааг хөгжүүлэхээр хэлэлцэгдэж буй газрууд | 63 |

ӨМНӨХ ҮГ

Улсын хэмжээнд 2019 онд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 489 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 123 хэргээр буюу 33.6 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн улмаас 2019 онд нийт 414 иргэн, 13 хуулийн этгээдэд 2,576,142,476 төгрөгийн хохирол учирснаас 2,027,765,753 төгрөгийг буюу 78.7 хувийг нөхөн төлүүлж, 700,957,273 төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн байна. Харин энэ оны эхний 4 сард нийт 274 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 112 хэргээр буюу 69.1 хувиар өссөн үзүүлэлттэй, улсын хэмжээнд бүртгэгдсэн 10130 хэргийн 2.7 хувийг эзэлж байна. Эдгээр тоон үзүүлэлтээс хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг тасралтгүй өсөж байгааг төвөггүй ойлгож болохоор байна.

Хамгийн харамсалтай нь байгаль орчныг сүйтгэсэн зөрчил, гэмт хэргийг тоон мэдээллээр үзүүлж, хохирлын хэмжээг мөнгөн нэгжээр хэмжиж болох ч экосистемд үзүүлж буй хор уршиг нь хэмжээлшгүй юм.

АНУ-ын Вашингтон хотноо 1973 онд амьтан, ургамлын худалдаа жилээс жилд өсөн нэмэгдэж, олон зүйлийн амьтан, ургамал устаж болзошгүй болсныг харгалзан дэлхийн улс орнууд ховордсон амьтан, ургамлын гадаад худалдааг олон улсын хэмжээнд хянан зохицуулах зорилгоор нэгэн чухал хэлэлцээрийг байгуулсан байдаг. Энэ бол “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora)” юм. CITES нэрээр дэлхий дахинаа түгэн дэлгэрч, олон улсад хүлээн зөвшөөрөгдөн мөрдөгдөж буй тус конвенцод манай улс 1996 онд 133 дахь гишүүн орон болж нэгдэн орсон. Үүнээс гадна, Монгол Улс нь зэрлэг амьтан, ургамал, тэдгээртэй холбогдох харилцааг зохицуулсан олон улсын 6 конвенц болон протоколд нэгдэн орсон байдаг. Энэ бол Монгол Улс, монголчууд бидний олон улсын өмнө хүлээсэн үүрэг юм.

Дэлхийн Улаан дансны ангиллын шалгуураар борцгор хотон нь устаж байгаа зүйлд хамаардаг нэн ховор зүйл шувуу бөгөөд Монгол Улсад 100 хүрэхтэй үгүйтэй хотон өндөглөн зусдаг мэдээ байна. Ховордсон гол шалтгаан нь хотонгийн хошуугаар хийсэн хусуур хэрэглэвэл морь хурдалдаг гэх ташаа ойлголт. Олон нийтийн дунд тархсан буруу мэдээлэл, ташаа ойлголтын үр

дагавар нь хууль бус агнуур, худалдаа, цаашилбал ургамал, амьтны төрөл зүйлийн мөхөл, байгаль экологийн нөхөж баршгүй сүйрэл дагуулж байгаа нь эмгэнэлтэй.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран олон ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал, жил бүр Байгалиа хамгаалъя арга хэмжээг зохион байгуулж, тус арга хэмжээний хүрээнд олон нийтийг соён гэгээрүүлэх, хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдыг сургаж, чадавхжуулах гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгэж ирлээ. Үүнээс гадна, энэ чиглэлийн судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага, мэргэшсэн мэргэжилтнүүдтэй хамтран хийж байна.

Аливаа төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тэр дундаа амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хууль бусаар улсын хил нэвтрүүлэх, худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход хөрш орнуудын төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах, харилцан туршлага солилцох зайлшгүй шаардлагатай байдаг. Ийм ч учраас уул нуруу, ус мөрнөөр холбогдсон мөнхийн хөрш хоёр оронтой энэ чиглэлээр хийгдсэн гэрээ хэлэлцээр, түүний хэрэгжилтийн байдал, хууль бус худалдаа, агнууртай хамтран тэмцэх, урьдчилан сэргийлэх, цаашдын хамтын ажиллагааны талаар дүн шинжилгээ хийж, өнөөгийн нөхцөл байдлыг танилцуулсан энэхүү судалгааны тайланг хэвлүүлэн хүргэж байна.

Хүрээлэн байгаа орчноо хайрлах сэтгэлтэй хэн бүхэнд хэрэгтэй, эх байгальд ээл тусаа өгөх нэгэн ажил болсон хэмээн найдахын сацуу байгаль, дэлхийнхээ сайн сайхны төлөө хийх үйлс бүхэн улам дэлгэрэн батжихын ерөөл талбия.

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Л.НЯМГЭРЭЛ

УДИРТГАЛ

Монгол Улс нь Төв Азийн элгэнд ОХУ, БНХАУ-тай хил залган Сибирийн тайга, Евро-Ази болон Төв Азийг хамран үргэлжилсэн тал хээр, говь цөлийг дамнан орших бөгөөд Хойд мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсгалгүй гурван том ай савын хагалбар нутаг юм. Газарзүйн өвөрмөц тогтолцоо, эртнээс эрхэлж ирсэн нүүдлийн мал аж ахуй, зан заншил, хүн амын сийрэг суурьшил нь Монгол орныг Евроази дахь хүн ба байгалийн зэрэгцэн оршин тогтнох үйл явц, дэлхийд устан үгүй болж буй экосистем, ховордсон ургамал, амьтны зүйлийг хамгаалан үлдэхэд нэн чухал орон зай болгожээ. Манай оронд экосистемийн 16 үндсэн төлөөлөл байдаг бөгөөд тэдгээрийн байгаль хамгаалал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг сайжруулах зорилгоор Дагуурын хээр (нийт нутгийн 28,2%), Хангай (нийт нутгийн 16,4%), Төв Азийн говь цөл (нийт нутгийн 32,3%), Алтай Саяны (нийт нутгийн 23,1%) гэсэн дөрвөн үндсэн эко бүст хуваадаг байна.

Эрс тэс уур амьсгалтай Монгол оронд өөр хоорондоо ялгаатай олон янзын экосистемд дасан зохицсон 39 баг, 112 овог, 683 төрөлд хамаарах 3127 зүйл, дэд зүйлийн гуурст ургамал, 105 овгийн 288 төрлийн 1400 орчим зүйлийн замаг, 510 орчим зүйлийн хөвд, 10 овгийн 15 төрлийн 7 зүйлийн шивэрсэн хэлбэртэн, 556 зүйлийн дээд ургамал, 3 овгийн 6 төрлийн 22 зүйлийн нүцгэн үрт ургамал, 138 зүйлийн хөхтөн, 75 зүйлийн загас, 22 зүйлийн мөлхөгч, 6 зүйлийн хоёр нутагтан, 476 зүйлийн шувуу, 13 мянга гаруй зүйлийн шавж, 516 зүйлийн зөөлөн биетэн амьтад бүртгэгджээ.

Байгалийн ургамал, амьтны популяцийн олон жилийн тандалт судалгаанаас үзвэл, тэдгээрийн тоо толгой буурах, нөөц хомсдох, амьдрах, ургах орчин нь доройтон тархац нутаг нь хумигдах хандлагатай байна. Амьтны тоо толгой буурах, ургамлын нөөц хомсдоход уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт хуурайшил, ой, хээрийн түймэр зэрэг байгалийн хүчин зүйлс нөлөөлж байгаагаас гадна, малын тоо толгойн хэт өсөлт, бэлчээрийн талхагдал, хөрсний элэгдэл, уул уурхай, газар тариалангийн үйл ажиллагаа, дэд бүтцийн хөгжил, хотжилт, хууль бус хэт ашиглалт зэрэг хүний хүчин зүйлс голлон нөлөөлж байна.

Дээрх хүчин зүйлсийн нөлөөгөөр хөхтөн амьтдын зүйлийн 16% нь бүс нутгийн хэмжээнд устах аюултай, 2% нь устаж байгаа, 11% нь устаж болзошгүй, 3% нь эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр, шувуудын зүйлийн 4% нь тоо

толгой буурсан, нэн ховор, ховор ургамлын зүйлийн 11% нь устаж байгаа, 26% нь устаж болзошгүй, 37% нь эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр, 15% нь ховордож болзошгүй байна. Мазаалай баавгай, Монгол бөхөн, тахь адуу нь зөвхөн Монгол оронд тархсан уугуул амьтад бөгөөд цоохор ирвэс, аргаль хонь, хар сүүлт, хавтгай тэмээний дэлхийн тархац нутгийн хамгийн хойд зах нь манай улсад оршдог учраас эдгээр амьтдыг илүүтэйгээр хамгаалах шаардлагатай байна¹.

Монгол Улс нь амьтан, ургамлын аймгийг хамгаалах, зохистой ашиглах талаар Монгол Улсын Үндсэн хуульд тусгаж, Байгаль орчныг хамгаалах багц хуулиудыг батлан хэрэгжүүлж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030², Төрөөс экологийн талаар баримтлах бодлого³, Ногоон хөгжлийн бодлого⁴ зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж байгаагаас гадна, амьтан, ургамлыг хамгаалах чиглэлээр олон улсын 4 конвенцид нэгдэн орсон байна. Өнөөдрийн байдлаар байгалийн ургамал, амьтныг хамгаалах, зохистой ашиглах харилцааг зохицуулсан 11 хууль, тэдгээрт нийцүүлсэн 20 гаруй журмыг мөрдөн хэрэгжүүлж байна.

Хэдийгээр хууль тогтоомж, стандарт, хэрэгжүүлэх журам, процедурыг тогтоосон эрх зүйн орчин хангалттай бүрдсэн боловч тэдгээр хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжилтийн явцад олон доголдол байна⁵.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, хууль, хяналтын байгууллагын чадавх сул байгаагаас амьтан, ургамлын хууль бус худалдааны зөрчил буурахгүй, харин ч нуугдмал далд, нарийн зохион байгуулалтад орж цөлмөн ашиглах явдал улам өссөөр байгаа нь ихээхэн анхаарал татаж байгаа юм.

ПРОФЕССОР, ДОКТОР (Ph.D) Ч.НЯМСҮРЭН

1 Байгалийн ургамал, амьтны өнөөгийн төлөв байдал, цаашид авах арга хэмжээ. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанд тавьсан Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын илтгэл. 2013.01.08

2 Монгол Улсын Их Хурал. 2016.2.5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор баталсан.

3 Монгол Улсын Их Хурал. 1997.12.26-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан.

4 Монгол Улсын Их Хурал. 2014.6.13-ны өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан.

5 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл. УБ.,2018. 15 дахь тал.

ТОВЧИЛСОН ҮГС

| | |
|--------|---|
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| БНМАУ | Бүгд Найрамдах Монгол Ард Улс (хуучнаар) |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БНКазУ | Бүгд Найрамдах Казакстан Улс |
| ГЕГ | Гаалийн ерөнхий газар |
| ЗЗОБ | Засаг захиргааны онцгой бүс |
| МХЕГ | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| НҮБ | Нэгдсэн Үндэсний Байгууллага |
| НҮБХХ | Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| ӨМӨЗО | Өвөр Монголын Өөртөө засах орон |
| УИХ | Улсын Их Хурал |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |

ТАЛАРХАЛ

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар болон тэдгээрийн харьяа яам, агентлагуудын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээр, протокол, харилцан ойлголцлын санамж бичгүүд дэх хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил, ялангуяа зэрлэг амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний хууль бус худалдаа, агнууртай хамтран тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх агуулгыг судалж, дүн шинжилгээ хийх, цаашид холбогдох талуудтай хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох санаачилгыг гаргаж, тайланг нэгтгэн боловсруулж, санхүүжүүлж дэмжин ажилласан Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)–ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын захирал Д.Батболд, байгаль хамгааллын асуудал хариуцсан захирал Б.Чимэддорж, хууль бус агнуур, худалдааны асуудал хариуцсан зөвлөх С.Пүрэвсүрэн болон тус байгууллагын нийт хамт олонд талархлаа илэрхийлье.


Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэж, хамтран ажилласан Дотоод хэргийн их сургуулийн профессор, доктор (Ph.D) Ч.Нямсүрэн, тус сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч Д.Бадамцэцэг, зөвлөхөөр ажилласан Дотоод хэргийн их сургуулийн Гэмт хэрэг илрүүлэхүйн профессорын судалгааны багийн профессор, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа М.Эрдэнэбаяр нарт баярлалаа.

Тус судалгааны ажлыг нарийвчлан төлөвлөж, талуудаас холбогдох баримт бичиг, материалуудыг цуглуулж, энэ судалгааны ажлыг гүйцэтгэх боломж нөхцөлийг бүрдүүлж, хамтын ажиллагааг ханган ажилласан Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны шинжээч, цагдаагийн дэд хурандаа М.Отгонжаргал болон Ажлын албаны нийт хамт олондоо талархал илэрхийлье.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН
ГАРАЛТ, ТҮҮНИЙ ДОТОР ХУУЛЬ БУСААР АН
АГНАХ, БАЙГАЛИЙН УРГАМАЛ ТҮҮЖ, БЭЛТГЭХ
ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ




1.1

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эрүүгийн хуульд заасан Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн статистик мэдээллийг 2013-2018 оны 8 дугаар сар хүртэлх хугацаагаар зааглан харьцуулан үзэхэд, нийт 1591 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 1389 буюу 87.3% нь нь орон нутагт, 202 буюу 12.7% нь нийслэлд үйлдэгдсэн байна.

Зураг 1. Байгаль хамгаалах журмын эсрэг болон хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн байдал (улс, нийслэл, орон нутгаар, 2013-2017 он¹, 2018.I-VIII сар)




Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн (2002 оны хуулиар) түвшинг өмнөх оны түвшинтэй харьцуулан үзэхэд, 2014 онд 50 хэргээр буюу 14.8%, 2015 онд 59 хэргээр буюу 20.6%, 2016 онд 63 хэргээр буюу 27.6%-аар тус тус буурч, 2017 онд 165 хэргээр буюу 2.0 дахин өссөн байна².

Энэ төрлийн гэмт хэргийн 213 буюу 13.4% нь баруун бүсэд, 440 буюу 27.7% нь хангайн бүсэд, 599 буюу 37.7% нь төвийн бүсэд, 136 буюу 8.5% нь зүүн бүсэд тус тус бүртгэгдсэн байна.


1 Сүүлийн 5 жилээр энэ төрлийн гэмт хэргийн гаралт, хөдөлгөөнийг авч үзэхдээ 2013-2017 оныг сонгосон нь УИХ-аас 2002 онд баталсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23 дугаар бүлэгт Байгаль хамгаалах журмын эсрэг 14 гэмт хэрэг хуульчлагдан мөрдөгдөж байсан, 2018 оны 8 дугаар сар хүртэлх хугацааг тусгайлан авч үзсэн нь УИХ-аас 2015 онд баталж, 2017 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт тусгагдсан Хүрээлэн байгаа орчны эсрэг 9 гэмт хэргийн заалтын хэрэгжилтийг тэгшитгэн авч, дүн шинжилгээ хийх зорилгоор тус заасан хугацаануудаар хязгаарлан авч үзсэн болно.

2 ЦЕГ. Монгол Улсад 2013-2017 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт. Улаанбаатар, 2018

Зураг 2. Байгаль хамгаалах журмын эсрэг болон Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (бүс, нийслэлээр, 2013-2017 он, 2018.1-VIII сар)



Зураг 3. Байгаль хамгаалах журмын эсрэг болон Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (аймаг, дүүргээр, 2013-2017 он, 2018.1-VIII сар)



Энэ төрлийн гэмт хэргийг дундажлан авч үзвэл, 2013-2017 он, 2018 оны эхний 8 сарын байдлаар орон нутагт дунджаар 66 хэрэг, нийслэлд 22 хэрэг бүртгэгджээ.

Гэмт хэргийн бүртгэгдсэн байдлыг авч үзвэл, Сэлэнгэ аймагт 268, Төв аймагт 159, Хөвсгөл, Өвөрхангай аймгуудад 110-109 гэмт хэрэг бүртгэгдсэн нь хамгийн өндөр, Говьсүмбэр, Дундговь аймгуудад 1-5 гэмт хэрэг бүртгэгдсэн нь хамгийн бага үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн хэргийг хүчин төгөлдөр үйлчилж буй хугацаа, зүйл ангиар нь ялган авч үзвэл, 2013-2017 онд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг (2002 оны Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэг) 1347 бүртгэгдсэний дотор 733 буюу 54.4% нь ойн тухай хууль тогтоомж зөрчих, 264 буюу 19.6% нь хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, 217 буюу 14.9% нь ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих, 79 буюу 5.9% нь байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчих, 48 буюу 3.6% нь ой, хээрийн түймэр тавих, 11 буюу 0.8% нь газрын хөрс, усыг бохирдуулах, 7 буюу 0.5% нь усны тухай хууль тогтоомж зөрчих, 2 буюу 0.1% нь тус бүр газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих, химийн гаралтай хорт бодис, үйлдвэрлэлийн хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх, булшлах журам зөрчих гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Эрүүгийн хууль (2002 он) дахь Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн үйлдэгдсэн байдлыг зүйл бүрээр нь харуулбал³

| № | Зүйл анги (2002 оны Эрүүгийн хуулиар) | 2013 он | 2014 он | 2015 он | 2016 он | 2017 он | 5 жилийн байдлаар |
|----|---|---------|---------|---------|---------|---------|-------------------|
| 1. | Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих (Эрүүгийн хууль (2002)-ийн 203 дугаар зүйл) | 32 | 50 | 47 | 30 | 42 | 201 |
| 2. | Газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих (Эрүүгийн хууль (2002)-ийн 204 дүгээр зүйл) | | | 1 | 1 | | 2 |
| 3. | Химийн гаралтай хорт бодис, үйлдвэрлэлийн хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх, булшлах журам зөрчих (Эрүүгийн хууль (2002)-ийн 206 дугаар зүйл) | 1 | | | | 1 | 2 |
| 4. | Газрын хөрс, усыг бохирдуулах (Эрүүгийн хууль (2002)-ийн 207 дугаар зүйл) | 3 | 1 | | 1 | 6 | 11 |
| 5. | Усны тухай хууль тогтоомж зөрчих (Эрүүгийн хууль (2002)-ийн 208 дугаар зүйл) | 2 | 2 | 1 | | 2 | 7 |
| 6. | Ойн тухай хууль тогтоомж зөрчих (Эрүүгийн хууль (2002)-ийн 211 дүгээр зүйл) | 245 | 177 | 111 | 72 | 128 | 733 |

³ 2002 онд УИХ-аас баталсан “Эрүүгийн хууль”-д байгаль хамгаалах журмын эсрэг 14 төрлийн гэмт хэрэг, түүн дотроос зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдаа, агнууртай холбоотой 2 төрлийн гэмт хэргийг хуульчилжээ. Мөн тус хуулийн 175 дугаар зүйлийн “Эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлэх” гэмт хэрэгт хориглосон буюу хязгаарласан эд зүйлийг бага бус хэмжээгээр, ховор амьтан, ... байгалийн төрцийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

| | | | | | | | |
|-------------|--|------------|------------|------------|------------|------------|-------------|
| 7. | Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчих (Эрүүгийн хууль (2002)-ийн 212 дугаар зүйл) | 7 | 7 | 15 | 17 | 33 | 79 |
| 8. | Ой, хээрийн түймэр тавих (Эрүүгийн хууль (2002)-ийн 213 дугаар зүйл) | 6 | 11 | 15 | 9 | 7 | 48 |
| 9. | Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох (Эрүүгийн хууль (2002)-ийн 214 дүгээр зүйл) | 41 | 39 | 38 | 35 | 111 | 264 |
| Нийт | | 337 | 287 | 228 | 165 | 330 | 1347 |

Харин 2018 оны эхний 8 сард хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн 24 дүгээр бүлэг) 244 бүртгэгдсэний дотор 115 буюу 47.1% нь хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, 98 буюу 40.2% нь хууль бусаар мод бэлтгэх, 16 буюу 6.6% нь хууль бусаар ан агнах, 9 буюу 3.7% нь ой хээрийн түймэр тавих, 2 буюу 0.8% нь тус бүр байгаль орчныг бохирдуулах, байгалийн тэнцэл алдагдуулах, байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэргүүд байна.

Хүснэгт 2. Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) дахь Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн үйлдэгдсэн байдлыг зүйл бүрээр нь харуулбал⁴

| № | Зүйл анги | 2018 оны I-VIII сар |
|-------------|--|---------------------|
| 1. | Хууль бусаар ан агнах (Эрүүгийн хууль (2015)-ийн 24.5 дугаар зүйл) | 16 |
| 2. | Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах (Эрүүгийн хууль (2015)-ийн 24.3 дугаар зүйл) | - |
| 3. | Байгаль орчныг бохирдуулах (Эрүүгийн хууль (2015)-ийн 24.1 дүгээр зүйл) | 2 |
| 4. | Байгалийн тэнцэл алдагдуулах (Эрүүгийн хууль (2015)-ийн 24.9 дүгээр зүйл) | 2 |
| 5. | Хууль бусаар мод бэлтгэх (Эрүүгийн хууль (2015)-ийн 24.6 дугаар зүйл) | 98 |
| 6. | Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх (Эрүүгийн хууль (2015)-ийн 24.8 дугаар зүйл) | 2 |
| 7. | Ой, хээрийн түймэр тавих (Эрүүгийн хууль (2015)-ийн 24.7 дугаар зүйл) | 9 |
| 8. | Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох (Эрүүгийн хууль (2015)-ийн 24.2 дугаар зүйл) | 115 |
| Нийт | | 244 |

⁴ Харин шинэчлэн найруулсан "Эрүүгийн хууль"-д Хүрээлэн байгаа орчны эсрэг 9 төрлийн гэмт хэргийг хуульчилснаас зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдаа, агнууртай холбоотой 2 төрлийн гэмт хэрэг байна.



© Каненори Мисора

Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил. Элбэг тархацтай амьтан агнах үйлдлийг Эрүүгийн хуулиар хамгаалаагүй. Харин Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд тусгайлан оруулж өгчээ.

Зөвшөөрөлгүй, хууль бусаар элбэг тархацтай амьтныг агнасан, хадгалсан, худалдсан худалдан авсан субъектуудыг тодорхой зааж өгсөн байна. Иргэн зөвшөөрөлгүй элбэг тархацтай амьтныг агнасан тохиолдолд иргэнийг 150 мянган төгрөгөөр торгох, хуулийн этгээдийг 1 сая 500 мянган төгрөгөөр торгохоор тусгажээ.

2015-2017 онд зэрлэг амьтныг хамгаалахын эсрэг 142 зөрчлийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулиар 28 үйлдэлд, Амьтны тухай хуулиар 49 үйлдэлд, Гаалийн тухай хуулиар 64 үйлдэлд арга хэмжээ авчээ. Үүнээс гаалийн байгууллага 59 зөрчлийг, мэргэжлийн хяналтын байгууллага 83 зөрчлийг тус тус хянан шийдвэрлэжээ.

2018 оны эхний 8 сарын байдлаар дээрх зөрчил 11 бүртгэгдэж, зөрчил гаргасан иргэдэд нийт 700.000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулсан байна.


2015-2017 онд ургамал хамгаалах журмын эсрэг нийт 81 зөрчил хянан шийдвэрлэсэнээс Мэргэжлийн хяналтын газар 8, Гаалийн ерөнхий газар 62, Цагдаагийн ерөнхий газар 11 зөрчлийг хянан шийдвэрлэжээ. Үүнээс Зөрчлийн тухай хуулиар 7, Байгалийн ургамлын тухай хуулиар 1, Гаалийн тухай хуулиар 62 үйлдлийг хянан шийдвэрлэжээ.

1.2

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧРУУЛСАН ХОХИРОЛ

Улсын хэмжээнд 2013-2017 он, 2018 оны эхний 8 сард бүртгэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн улмаас нийт 95.6 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 76.6 тэрбум буюу 80.2%-ийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, 113.6 тэрбум төгрөгийн эд хөрөнгө битүүмжилж, 19.0 тэрбум төгрөг буюу 19.8%-ийн хохирол нөхөн төлөгдөөгүй байна.

Зураг 4. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт (сая.төгрөг)



Хүснэгт 3. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн байдал (сая.төгрөг)

| № | Үзүүлэлт | 2013 он | 2014 он | 2015 он | 2016 он | 2017 он | 2018 оны 1-8 сар |
|---|-------------------------|----------|---------|---------|---------|---------|------------------|
| 1 | Нийт учирсан хохирол | 63043.3 | 3299.6 | 10270.4 | 4856.4 | 4352.4 | 9755.2 |
| 2 | Хохирол нөхөн төлүүлэлт | 61364.0 | 2252.4 | 8770.7 | 2653.1 | 1202.5 | 369.2 |
| 3 | Битүүмжилсэн хөрөнгө | 100728.3 | 2211.4 | 3956.7 | 4381.7 | 1911.4 | 426.7 |

Нэгдүгээрт, шинээр хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Эрүүгийн хуульд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болсноор гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, гэмт хэрэг цагдаагийн байгууллагад ихээр бүртгэгдэж нэмэгдсэн байна. Жишээ нь хуучин хэрэгжиж байсан Эрүүгийн хуулиар хохирол шаарддаг материаллаг бүрэлдэхүүнтэй байсан учраас хохирлын хэмжээнд хүрэхгүй үндэслэлээр гэмт хэрэгт бүртгэгдэхгүй, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай шийдвэрлэгдэж байсан бол шинэ хуулиар хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болсноор хохирол шаардахгүйгээр цагдаагийн байгууллага шалгадаг болсон.

Хоёрдугаарт, шинэчилсэн хууль хэрэгжиж эхэлснээс хойш цагдаагийн байгууллагын хэмжээнд хяналт шалгалтыг тодорхой үе шаттайгаар улсын хэмжээнд зохион явуулсны үр дүнд гэмт хэргийн илрүүлэлтийн тоо болоод гэмт хэргийн илрүүлэлт өссөн дүнтэй харагдаж байна.



1.3

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЖ

Амьтан, ургамлын аймагт халдах гэмт үйлдлийг эрүүгийн эрх зүйгээр хамгаалсан заалт шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль (2015 он)-д дараах байдлаар туссан байна. Үүнд:

- Эрүүгийн хууль (2015)-ийн 18.5 дугаар зүйлд: Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх зүйлд Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу **хориглосон, хязгаарлалт**⁵ тогтоосон барааг эртний **амьтны, ургамлын** өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, ... Монгол Улсын хилээр, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол;
- 19.6 дугаар зүйл. Хорлон сүйтгэх зүйлд: Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, батлан хамгаалах, эдийн засгийн хүчин чадлыг сулруулах зорилгоор хүн, **амьтан, ургамлын** гоц халдварт өвчин тараасан бол...;
- 24.1 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдуулах зүйлд: Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж **амьтан, ургамал**, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бол;
- 24.9 дүгээр зүйл. Байгалийн тэнцэл алдагдуулах зүйлд: **Амьтан, ургамлын** зүйлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээсэн, устгасан, экологийн тогтолцоог алдагдуулсан бол хариуцлага оногдуулахаар байгаа бөгөөд амьтан, ургамлын аймгийг шууд хамгаалах тусгайлсан зүйл заалтыг мөн хуульчилсан байна.

5 Үзнэ үү: Хориглосон хязгаарласан барааны жагсаалт

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн Хууль бусаар ан агнах⁶, 24.8 дугаар зүйлийн Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх⁷ зэргийг нэрлэж болохоор байна.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн бодит үйлдлийг дараах байдлаар тодорхойлж, ховор амьтныг агнасан хууль бус үйлдэлд нэгээс таван жил хариуцлага оноох бол нэн ховор амьтныг онцгойлон үзэж хариуцлагыг хүндрүүлэн 2-8 жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заажээ.

Тус хуульд заасан обьектив үйлдэлд:

- Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан,
- Нэн ховор, ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан;
- Нэн ховор, ховор зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн;
- Ховор амьтны түүхий эдийн зүйлийг хадгалсан;
- Нэн ховор амьтны түүхий эдийг бэлтгэсэн;
- Нэн ховор, ховор амьтны түүхий эдийг худалдсан;
- Нэн ховор, ховор амьтны түүхий эдийг худалдан авсан;
- Нэн ховор, ховор амьтны түүхий эдийг тээвэрлэсэн;
- Нэн ховор, ховор амьтны түүхий эдийг гадаад улсад гаргасан;
- Ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн;
- Нэн ховор, амьдрах орчныг алдагдуулсан гэж заасан байна.

Амьтны эд эрхтэн, түүхий эд нь амьтны арьс, мах, цус, эвэр, булчирхай, тос, өөх зэрэг байх бөгөөд түүгээр хязгаарлагдахгүй юм.

Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлд зааснаар өөрөө ан хийгээгүй ч бусдаас амьтны эд эрхтнийг худалдан авсан, бусдад худалдсан, тээвэрлэсэн, хадгалсан, гадаад улсад гаргасан, чихмэл, цуглуулга хийсэн, амьдрах

6 24.5 дугаар зүйл. Хууль бусаар ан агнах

1.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

7 24.8 дугаар зүйл.Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх

1.Зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтэнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

орчныг алдагдуулсан зэрэг үйлдэл нь энэ зүйлээр хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна.

Дээрх зүйлээс харвал, хууль зүйн техникийн алдаа байх боломжтой нэг зүйл байгаа нь “ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол” хариуцлага хүлээлгэхээр зааж, харин нэн ховор амьтны чихмэл, түүхий эдийн цуглуулга хийсэн үйлдлийг хариуцлага тооцуулахгүйгээр орхигдуулжээ.

Эрүүгийн хууль тогтоомжийн эх сурвалжид Монгол Улсын Үндсэн хуулиас гадна, олон улсын конвенц нь мөн адил эх сурвалж болохыг Эрүүгийн хуульд тусгасан байдаг. Эрүүгийн хуулийн үйлчлэлийн хүрээнд хамаарах амьтныг хамгаалах олон улсын хэд хэдэн гэрээ, конвенцид манай улс нэгдэн орж, соёрхон баталсан төдийгүй Биологийн олон янз байдлын тухай конвенц⁸, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц⁹, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц¹⁰, Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцийн¹¹ үзэл санаа нь манай улсын Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн агуулгад зохих хэмжээгээр тусжээ.

Тухайлбал, байгалийн ургамлын хувьд гэхэд зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтнийг:

- түүсэн;
- бэлтгэсэн;
- худалдсан;
- худалдан авсан;
- хадгалсан;
- тээвэрлэсэн;
- боловсруулсан зэрэг идэвхтэй объектив үйлдлийг хуульчилжээ.

Хууль бусаар ан агнах, байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл. Манай улсад зэрлэг амьтан, ургамлын нөөцийг эм, хүнс, соёлын чиглэлээр дотооддоо хэрэглэх хэрэгцээ бусад оронтой харьцуулахад төдийлөн их биш юм. Гэвч хөрш орнуудын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дагаж, манай улсад олон зүйлийн амьтан, ургамал хууль бус ашиглалтад өртсөөр байна. Хууль хяналтын байгууллагын илрүүлсэн амьтан,

8 Биологийн олон янз байдлын тухай конвенц. //Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. 2010. №9

9 Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц. //Төрийн мэдээлэл. Тусгай дугаар 2010. №9

10 Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц. /Төрийн мэдээлэл. Тусгай дугаар 2010. №9

11 Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц. /Төрийн мэдээлэл. Тусгай дугаар 2010. №9

ургамлын хууль бус худалдааны зөрчлийн сүүлийн 3 жилийн мэдээнээс үзвэл, энэ төрлийн худалдаа далд, нарийн зохион байгуулалтад шилжсэн байна. Мөн хууль, хяналтын байгууллагад байгаль орчны чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай байгаа ба зөрчлийн илрүүлэлт маш сул байна.

Байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар их хэмжээгээр түүж ашиг олж байгаа ч эргээд нөхөн сэргээлт, тарималжуулалт хийдэггүйгээс чихэр өвс, цагаан гаа, хусны онгол, туруу мөөг зэрэг ургамлын нөөц хомсдож байна.

Энэ төрлийн гэмт хэрэг нь иргэдийн амар хялбар аргаар мөнгө, хөрөнгө олох хүсэл, ховор ургамал, амьтны эд эрхтнийг хэрэглэх гэсэн ашиг сонирхлоос шалтгаалан ихэвчлэн үйлдэгдэж байна.

Байгалийн баялгийг ашиглахад заавал зөвшөөрөл авдаг учраас түүнийг олгодог, хянадаг төрийн байгууллагын үйл ажиллагаа зохих ёсоор явагддаггүй, төрийн алба хаагчдад хувийн эрх ашгаа нэгдүгээрт тавьдаг, авлига хээл хахуульд өртөмтгий байдал, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоогүй, хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа хүртээмжгүй, арга барил нь хоцрогдсон байдал нь энэ төрлийн гэмт хэрэг гарах бас нэгэн нөхцөлийг бүрдүүлж байна.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас 2008 онд хийсэн “Мэдээлэл, сургалт, сурталчилгааг оновчтой хүргэх замаар ан амьтдын гаралтай эд зүйлсийн хууль бус худалдааг бууруулах нь (Байгаль орчны шинэчлэл II)” төслийн хүрээнд хийсэн судалгаанаас үзэхэд, судалгаанд хамрагдсан иргэд ан амьтдын ховордож байгаа гол шалтгааныг зарж борлуулах (25%), эмчилгээний зориулалтаар (18%) болон цэвэр ан агнуурын зорилгоор (18%) агнаж байгаатай холбоотой гэж үзжээ¹².

ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны мөрдөгчтэй хийсэн ярилцлагаас үзэхэд энэ нөхцөл байдал өөрчлөгдөөгүй байгааг баталж байна.

12 Дэлхийн байгаль хамгаалах сан /WWF/-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар. (2008). Мэдээлэл, сургалт, сурталчилгааг оновчтой хүргэх замаар ан амьтдын гаралтай эд зүйлсийн хууль бус худалдааг бууруулах нь (Байгаль орчны шинэчлэл II) гүйцэтгэлийн тайлан. Улаанбаатар

Амьтны эд эрхтэн хилээр хууль бусаар гаргадаг сүлжээ бий болоод олон жилийн нүүрийг үзэж байгаа билээ. Дорноговь аймгийн Замын-Үүд, Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэн, Сүхбаатар аймгийн Бичигт, Ховд аймгийн Булган боомтоор хууль бус ангийн эд эрхтэн их хэмжээгээр хилээр байнга гарч байгаа.

Шивээ хүрэн, Гашуун сухайтын хилийн боомтоор цоохор ирвэсийн арьс, баавгайн савар, доньд, тархи, Монгол бөхөнгийн эвэр их хэмжээгээр гаргах гэж байгаад баригдсан хэд хэдэн гэмт хэрэг гарсан. Гол зорилго нь зарж борлуулж, ашиг хонжоо олох...

Мөрдөгчтэй хийсэн ярилцлага. 2018.11.05

Сүүлийн жилүүдийн судалгаанаас харахад, 2008 оноос өмнө автомашин, спирт, ноолуур, тарваганы арьс ихээхэн хэмжээтэйгээр хууль бусаар хил нэвтрүүлэх хэрэг гардаг байсан бол 2010 оноос үндсэндээ зогсож, хил дамнасан зохион байгуулалттай мал хулгайлах, хууль бусаар ан агнах, байгалийн баялаг, алт, түүхийн дурсгалт үнэт эд зүйл, ховор олдвор гаргах нь нэмэгдэж, 2015 оноос ан амьтны эд эрхтэн, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, галт зэвсэг, хориглосон болон хязгаарласан барааг хууль бусаар хил нэвтрүүлэх хэрэг, зөрчлүүд ихээхэн үйлдэгдэж, гэмт этгээдүүдийн үйлдэл, арга ажиллагаа нь улам нарийсан зохион байгуулалттай шинж нь давамгайлах болсон байна.

Өмнөговь аймаг, ӨМӨЗО-ны Альша, Баяннуур, Дорноговь аймаг, ӨМӨЗО-ны Улаанцав аймгийн чиглэлүүдээр голчлон монгол иргэд, хятадын иргэдтэй тохирч хилийн боомт болон боомт бус газраар хөлдөөсөн чоно, ангийн арьс, эд эрхтнийг тээврийн хэрэгсэлд нуух, байгалийн баялаг, ховор ургамлын бүтээгдэхүүн хууль бусаар гаргах, хууль бусаар зэвсэг, галт хэрэгслийн наймаа хийх, өөр хүний бичиг баримтаар улсын хил зөрчих, нүүрсийг хувь хүмүүс хуйвалдан гаргах зөрчлүүд зогсоогүй байна.

ӨМӨЗО-ны Баяннуур аймгийн Линхэ хотын иргэн В. Л нь байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчиж, нэн ховор ургамал болох 13,500,000 төгрөгийн үнэлгээ бүхий 750 кг цөлийн аргамжин цэцгийг /цагаан гоёог/ төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр худалдан авч Монгол Улсын иргэн Ж-тай бүлэглэн Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутаг Цагаан хад гэх газарт 2010 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс 7 дугаар сарын 13-ны өдөр хүртэлх хугацаанд хадгалсан гэмт хэрэг үйлдсэн...

Шүүхийн шийтгэх тогтоолоос



© М.Уянбаар

Улсын хилээр хууль бусаар гарч байгаа бараа, түүхий эдийг шалган нэвтрүүлэх боомтоор нь тоймлон ангилан үзвэл:

- Замын-Үүд, Эрээний чиглэлээр бусдын бичиг баримт ашиглан хил зөрчих, хориотой буюу хязгаарласан бараа, түүх соёлын үнэт зүйл улсын хилээр нууж гаргах, хүний наймааны зорилгоор хүүхэд, эмэгтэйчүүдийг хуурч хилээр гаргах, хар тамхи мансууруулах бодис нэвтрүүлэх,
- Сүхбаатар, ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн чиглэлд боомт газраар хязгаарласан буюу хориотой бүтээгдэхүүн гаргах, ангийн арьс, хөлдөөсөн чоно гаргах, манайхаас экспортолж байгаа түүхий эдийг гаалиар бага хэмжээгээр мэдүүлж гаргах,
- Дорнод аймаг, ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн чиглэлд хятад, иргэд Монгол иргэдтэй бүлэглэн мал хулгайлах, хилээр хууль бусаар эд зүйл гаргах зэрэг зөрчлүүд гарч байна.

БНХАУ-ын иргэн, БНХАУ-ын Шинжаан мужийн Чингэл сумын оршин суугч С. Л нь 2010 оны 12 дугаар сард Ховд аймгийн Жаргалант сумаас Булган сум руу ховор ан амьтан болох баавгайн 2 ширхэг арьс, алтайн хойлог 14 ширхэг, чонын гавлын яс, ахуун шувуу зэрэг эд зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн гэмт хэрэг үйлдсэн...

Шүүхийн тогтоолоос



Энэ төрлийн гэмт хэрэг нь хөдөө хээр, зэвсэг хэрэгсэл ашиглан үйлдэгддэг, харин худалдаалах, тээвэрлэх, хадгалах, ашиглах үйлдэл нь зөвхөн худалдагч, худалдан авагч нарын дунд далд хэлбэртэй явагддаг, улсын хилээр тээврийн хэрэгсэлд нуух, тусгайлан тоноглол хийх зэрэг үйлдлүүд нь нуугдмал шинжтэй байдаг, нийгмийн хор аюулаар их гэмт хэрэг юм.

Уг гэмт хэргийн гаралтыг үнэлэхдээ нуугдмал түвшинг тогтоох¹³ нь чухал бөгөөд тухайн гэмт хэргийн нуугдмал шинж нь гэмт хэргийн статистикаас гадна, хүрээлэн буй орчны доройтлоос тодорхой харагдана.

Дээр дурдсан суурь шалтгаанаас гадна, дараах нөхцөл хууль бусаар ан агнах гэмт хэрэгт тодорхой нөлөөлөх хүчин зүйл болж байна.

13 Гэмт хэргийн нуугдмал байдлын түвшинг тогтоох нь хялбархан хийгдэх ажил биш юм. Түүнийг тодорхойлохын тулд судалгааны янз бүрийн аргыг хэрэглэх ёстой. Орчин үед статистикийн математик аргын тусламжтайгаар нуугдмал гэмт хэрэгт судалгаа хийж байна. Доктор Ц.Цэлмэг Байгаль орчны эсрэг зөрчил 1 жилд 15000 орчим бүртгэгдэж байгаагийн 20 орчим хувь нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй байхад эрүүгийн хэрэг үүсгэхгүйгээр захиргааны хариуцлага тооцсон, гааль дээр хураагдсан их хэмжээний амьтны эд эрхтний тоо зэргээс байгаль хамгаалах журмын эсрэг нэг гэмт хэргийн цаана 50 орчим гэмт хэрэг нуугдмал байна гэж дүгнэсэн нь зөвхөн хоёрхон шалгуураар тооцож гаргасан тул учир дутагдалтай юм.

АНУ-ын болон барууны орны хуульч эрдэмтэд нэг илэрсэн гэмт хэргийн ард 3-10 нуугдмал хэрэг байдаг гэж үздэг (Эрдэнэбаяр, М. (2015). Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн байцаах, урьдчилан сэргийлэх онол, арга зүйн асуудал. Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан диссертаци. Улаанбаатар)

а/ Үслэг ангийн худалдаа. Үслэг ангийн худалдаа нь ан амьтны эд, эрхтний худалдаанд томоохон хэсгийг бүрдүүлдэг бөгөөд тэдгээрийн үнэ ханш, худалдаалах тоо хэмжээ ч ихээхэн өсөж байна.

б/ Эмчилгээний зориулалтаар борлуулж буй амьтны эд эрхтний худалдаа. Ан амьтдын эд эрхтэн дорно дахины уламжлалт эмийн бүтээгдэхүүнд ордог гол түүхий эд учраас дотоодын болон гадаад зах зээлд эрэлт хэрэгцээ ихтэй, үнэ ханш өндөртэй.

в/ Ангийн махны худалдаа ба хэрэглээ. Ангийн махны худалдаа нь амьжиргааны эх үүсвэрийг хангах, дотоодын зах зээлийг бүрдүүлж байна. Үүнд; цагаан зээр, хар сүүлт, хулан, бор гөрөөс, зэрлэг гахай, тарвага, гол мөрний загаснууд, зарим тохиолдолд хандгай, буга, аргаль, янгир зэрэг тураг амьтан ч өртөж байна.

г/ Амьтдын эд эрхтний бусад худалдаа. Амьтдын эд эрхтнийг хүнс хоол, хувцас, бүтээгдэхүүн болгохоос гадна, ахуйн өөр хэрэгцээнд ашиглаж байна. Үүнд; агнуурын бус амьтад ч өртдөг. Тухайлбал, сүүлийн жилүүдэд шашин зан үйлийн холбогдолтой бөөгийн эд хэрэглэлд тасын өд, шар шувуу зэрэг амьтдын эд эрхтний эрэлт нэмэгдэж, агнуурын бус эдгээр амьтдыг авлах болсон. Түүнчлэн хотон шувууны хошуугаар хурдан морины хусуур хийх, худалдаа үйлчилгээний газруудад амьтны чихмэл, яс, эвэр, арьс зэргээр гоёх болсон нь ашиг орлого олох эдийн засгийн суурь шалтгааны нэг болж байна.

д/ Хууль бусаар ан агнах гэмт хэргийн шалтгаанд нөлөөлөх нөхцөлийн нэг нь амьтны эд, эрхтэн борлуулах худалдааны сүлжээ, захууд юм. Эрүүгийн хэрэг, зөрчлийг илрүүлэх, мөрдөх явцад хууль бус худалдааны идэвхтэй сүлжээ, зохион байгуулалт байгааг олж тогтоосон.

Ан амьтдын хууль бус худалдааны сүлжээ нь алс хол газраас тээвэрлэгдэн ирж, суурин газрууд болох хот, аймаг, сумын төвийн “малын түүхий эд” хэмээн нэрлэгдсэн нэгдсэн борлуулах цэгт төвлөрнө. Манай улсын сум суурин газруудад дор хаяж нэг түүхий эдийн цэг байгаа нь түүний тархалтын хэмжээг илэрхийлнэ. Тухайн бүтээгдэхүүн орон нутагт борлогдохгүй бол Улаанбаатар зэрэг томоохон зах зээл рүү тээвэрлэгдэнэ. Монголын хамгийн том зах болох нийслэл хотын “Цайз”, “Эмээлт”, “Налайх”, “Нарантуул”, “Хархорин”, “Хүчит шонхор” зэрэг газрууд нь зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн зарах үндсэн цэг болсон байна. Ан амьтны эд, эрхтэн тухайн зах дээр хэзээ ч ил зарагддаггүй, нууц далд байдаг учраас хэдий хэмжээний арилжаа явагдаж байгааг тодорхойлоход бэрхшээлтэй.

е/ Гэмт хэргийн үйлдэгдэх шалтгаан нөхцөлд галт зэвсэг ихээхэн үүрэгтэй байна. Монгол улсын хэмжээнд 2017 оны байдлаар мянган галт зэвсэг бүртгэлтэй байна.

Дээрх галт зэвсгийн 4% буюу 1718 нь харуул хамгаалалтын, 1% буюу 556 нь спорт урлагийн, 1% буюу 253 нь үзмэр урлагийн, 94% буюу 41131 нь ан агнуурын зориулалттай галт зэвсэг байгаагаас¹⁴ дүгнэхэд, хэчнээн иргэн ан агнуур хийх боломжтой нь тодорхой.

Энэ байдлаас үзэхэд, хууль бусаар ан агнах, байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэг нь жил бүр өсөн нэмэгдэх хандлагатай, буурах саармагжих шинж байдал ажиглагдахгүй байна.

Энэ төрлийн гэмт хэрэг нь нууц далд, зохион байгуулалттай үйлдэгдэж, байгаль орчинд учруулж буй хор уршиг өндөр хэвээрээ байна. Хууль бусаар амьтан, ургамлын эд эрхтнийг худалдаалах, хил дамжуулан зарж борлуулах, тээвэрлэх үйлдэл нь илүү давамгайлах шинжтэй байна.

Энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нь хувь хүний шунал хүсэлтэй шууд холбоотой бөгөөд түүнд нөлөөлөх хүчин зүйл нь хуулийн хэрэгжилт хангалтгүй, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны чадавх сул, хүний нөөцөөр дутмаг, нийгмийн зүгээс нөлөөлөх хүчин зүйл их байна.

Мөн иргэдийн байгаль орчинтойгоо харьцах соёл, хандлага, зан төрх өөрчлөгдөхгүй байгаа нь төрлийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтад нөлөөлж байж болзошгүй юм.

14 Цагдаагийн ерөнхий газрын галт зэвсгийн жил бүрийн тайлан





ХОЁРДУГААР БҮЛЭГ


МОНГОЛ УЛСЫН ХОЛБОГДОХ ХУУЛЬ
ТОГТООМЖ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР,
ТЭДГЭЭРИЙН АГУУЛГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

2.1

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТЭДГЭЭРИЙН АГУУЛГА

2018 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 660 хуулиас 110 орчим хуульд хүрээлэн буй орчны асуудлыг зохицуулсан зүйл, заалтууд тусгагдсан байна. Эдгээр 110 орчим хуулиас зэрлэг амьтан, ургамалтай холбоотой харилцааг зохицуулсан 11 хууль, түүнтэй нийцүүлэн Монгол Улсын Засгийн газраас хуульчилсан актыг баталж, даган мөрдөж байна. Улмаар Монгол Улс нь амьтан, ургамал, тэдгээртэй холбогдох харилцааг зохицуулсан 6 төрлийн олон улсын гэрээнд нэгдэн оржээ.

Зураг 5. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжууд, тэдгээрийн дотор хүрээлэн буй орчин болон амьтан, ургамалтай холбогдох хууль тогтоомжуудын эзлэх хувь



Монгол Улсын Үндсэн хууль¹. Монгол Улсын Үндсэн хуульд хүрээлэн буй орчин, амьтан, ургамлын талаарх эрх зүйн зохицуулалт дараах байдлаар тусгагджээ. Үүнд:

¹ Монгол Улсын Үндсэн хууль нь 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдаж, 1992 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд оршил, 6 бүлэг, 70 зүйлээс бүрдэх тулгуур хууль юм.

- Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 6.1. дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, Зургаадугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” хэмээн төрийн хамгаалалтад байх эрх зүйн үндсийг тусгаж өгчээ.
- Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван дөрөвдүгээр зүйлд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” хэмээсэн нь Үндсэн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хүн бүр дээдлэн хууль дээдлэх зарчмыг тунхаглажээ.
- Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заажээ. Үүнээс үзэхэд, манай улсын эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг нь нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчим, гэрээ болох хууль зүйн үндэслэлийг тогтоосон чухал алхам болсон байна.
- Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэний үндсэн журамт үүргийг зааж өгсөн байдаг. Тухайлбал, Үндсэн хуулийн Арван долоодугаар зүйлийн 1, 2-т “Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; хуулиар ногдуулсан албан татвар төлөх; эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үндсэн үүргийг биелүүлэхийн зэрэгцээ хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” гэжээ.
- Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад нийтээрээ оролцох, шүүхэд хандах талаар иргэний эдлэх эрхийг Монгол Улсын Үндсэн хуульд тодорхой тусгасан байдаг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй”, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэжээ. Энэ нь Монгол

Улсыг Аархусын конвенц буюу “Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах талаарх конвенц”-д нэгдэн орох шаардлагатайг илэрхийлж байна.

Хүснэгт 4. Монгол Улсын хууль тогтоомжууд дахь амьтан, ургамалтай холбоотой эрх зүйн зохицуулалтууд

| № | Хуулийн нэр | Дагаж мөрдөх огноо | Хуулийн зохицуулалт |
|---|--------------------------------------|--------------------|--|
| 1 | Монгол Улсын Үндсэн хууль | 1992.02.12 | 6.1. дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн”. |
| 2 | Байгаль орчныг хамгаалах тухай хууль | 1995.03.30 | <ul style="list-style-type: none"> - Тухайн хуулиар амьтан, ургамал нь эрх зүйн харилцааны объект болохыг тодорхойлжээ. - Амьтан, ургамлыг хэрхэн ойлгох тухай заажээ. Тухайлбал, «ургамал» гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт ургадаг байгалийн болон таримал ой, мод, бүх төрлийн дээд, доод ургамал хамаарна; “амьтан” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавьж, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна” хэмээн тодорхойлж, уг ойлголтыг цаашид хэрхэн ойлгох талаар нэгдсэн зохицуулалтыг бий болгожээ. - Мөн амьтан, ургамлыг хамгаалах талаар төрийн болон иргэн, хуулийн этгээдийн эрх үүргийг хуульчилсан. |
| 3 | Амьтны тухай хууль | 2012.06.21 | Амьтан хамгаалах, эзэмших, ашиглах, ан агнуур, амьтны мэдээллийн сан, амьтан гадаад улсаас оруулах, гаргах болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд оногдуулах хууль зүйн хариуцлагыг тусгасан байна. Хэдий ийм боловч зэрлэг ан, амьтны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй ажээ. |

| № | Хуулийн нэр | Дагаж мөрдөх огноо | Хуулийн зохицуулалт |
|---|---|--------------------|--|
| 4 | Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль | 2002.12.23 | Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна. |
| 5 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль | 2012.06.21 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна. |
| 6 | Байгалийн ургамлын тухай хууль | 1995.06.05 | Ой болон таримал ургамлаас бусад ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулна. |
| 7 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль | 2012.06.21 | Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөцийн ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулна. |
| 8 | Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль | 2002.11.07 | Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийг хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулна. |

| № | Хуулийн нэр | Дагаж мөрдөх огноо | Хуулийн зохицуулалт |
|----|----------------------|--------------------|--|
| 9 | Зөрчлийн тухай хууль | 2017.07.01 | <p>7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих</p> <p>7.7 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих</p> <p>7.8 дугаар зүйл. Ургамал хамгааллын тухай хууль зөрчих</p> <p>7.9 дүгээр зүйл. Ойн тухай хууль зөрчих зэрэг зөрчлүүдийг дурдаж оногдуулах хууль зүйн хариуцлагыг дурдсан байна.</p> |
| 10 | Эрүүгийн хууль | 2017.07.01 | <p>24.5 дугаар зүйл. Хууль бусаар ан агнах</p> <p>24.6 дугаар зүйл. Хууль бусаар мод бэлтгэх</p> <p>24.7 дугаар зүйл. Ой, хээрийн түймэр тавих</p> <p>24.8 дугаар зүйл. Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх</p> <p>24.9 дүгээр зүйл. Байгалийн тэнцэл алдагдуулах зэрэг гэмт хэргүүдийг хуульчилж тэдгээрт оногдуулах хууль зүйн хариуцлагыг тогтоожээ.</p> |
| 11 | Гаалийн тухай хууль | 2008.07.01 | <p>Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэнээс гомдол гаргах, түүнийг гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.</p> |

2.2

МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ОЛОН ТАЛТ БОЛОН ХОЁР ТАЛТ ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР²

2017 оны 9 дүгээр сарын байдлаар Монгол Улс хүрээлэн буй орчны талаарх 23 төрлийн олон улсын олон талт гэрээнд нэгдэн орсон байна (Хүснэгт 5). Мөн Монгол Улсын Засгийн газар, БНКаЗУ-ын Засгийн газар хооронд Байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай, ургамлын хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрүүдийг баталсан байна. Монгол Улс нэгдэн орох шаардлагатай нэг конвенц бол Аархусын конвенц юм.

Хүснэгт 5. Монгол Улсын нэгдэн орсон олон талт конвенц, протокол

| № | Конвенцийн нэр | Байгуу- лагдсан огноо | Хүчин төгөлдөр болсон огноо | УИХ-аас соёрхон баталсан огноо | Монгол Улсын нэгдэн орсон огноо |
|----|---|-----------------------------|--------------------------------------|---|--|
| 1. | Биологийн олон янз байдлын тухай конвенц | 1992.06.05 | 1993.12.29 | 1993.09.24 | 1993.09.30 |
| 2. | Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын ерөнхий конвенц | 1992.05.09 | 1993.03.21 | 1994.09.24 | 1994.03.21 |
| 3. | Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц | 1979.06.23 | 1983.11.01 | 1996.01.05 | 1999 |
| 4. | Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц | 1973.03.03 | 1975.07.01 | 1995.05.04 | 1996.04.04 |
| 5. | Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц | 1985.03.22 | 1988.09.22 | 1995.10.16 | 1996.03.07 |

2 www.mfa.mn


| № | Конвенцийн нэр | Байгуулагдсан огноо | Хүчин төгөлдөр болсон огноо | УИХ-аас соёрхон баталсан огноо | Монгол Улсын нэгдэн орсон огноо |
|-----|--|---------------------|-----------------------------|--------------------------------|---------------------------------|
| 6. | Озоны үе давхаргад сөрөг нөлөө үзүүлэх бодисын тухай Монреалийн протокол | 1987.09.16 | 1989.01.01 | 1995.10.16 | 1996.03.07 |
| 7. | Озоны үе давхаргад сөрөг нөлөө үзүүлэх бодисын тухай Монреалийн протоколын Лондонгийн нэмэлт, өөрчлөлт | 1990.06.29 | 1992.08.10 | 1996.03.07 | 1996.03.07 |
| 8. | Озоны үе давхаргад сөрөг нөлөө үзүүлэх бодисын тухай Монреалийн протоколын Копенгагены нэмэлт, өөрчлөлт | 1992.11.25 | 1994.06.14 | 1996.03.07 | 1996.03.07 |
| 9. | Ган цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенц | 1994.10.14 | 1996.12.26 | 1996 | 1996.09.03 |
| 10. | Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг, ялангуяа усны шувуу олноор амьдардаг орчны тухай Рамсарийн конвенц | 1971.02.02 | 1975.12.21 | 1997 | 1997 |
| 11. | Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц | 1989.03.22 | 1992.05.05 | 1996.12.05 | 1997.04.15 |
| 12. | Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилга мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц | 1998.09.10 | 2004.02.24 | | 2001.03.08 |
| 13. | Байгалийн гамшгийг даван туулах, учирсан хохирлыг нөхөн барагдуулахад цахилгаан холбооны эх үүсвэрээр хангах тухай Засгийн газар хоорондын конвенц | 1998.06.18 | 2005.01.08 | 1998 | 1998.06.18 |
| 14. | Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Ерөнхий конвенцийн Киотогын протокол | 1997.12.11 | 2005.02.16 | 1999.07.08 | 1999.12.15 |

| № | Конвенцийн нэр | Байгуулагдсан огноо | Хүчин төгөлдөр болсон огноо | УИХ-аас соёрхон баталсан огноо | Монгол Улсын нэгдэн орсон огноо |
|-----|--|---------------------|-----------------------------|--------------------------------|---------------------------------|
| 15. | Халим агнуурыг зохицуулах тухай олон улсын конвенц | 1946.12.02 | 1948.11.10 | 2002.05.16 | 2002.05.16 |
| 16. | Биологийн төрөл зүйлийн тухай конвенцийн биоаюулгүй байдлын тухай Картагены протокол | 2000.01.29 | 2003.09.11 | 2003.07.22 | 2003.07.22 |
| 17. | Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай конвенцид Монреалын протоколын 9 дүгээр хуралдаанаас оруулсан нэмэлт, өөрчлөлт | 1997.09.17 | 1999.11.10 | 2002.03.18 | 2002.03.28 |
| 18. | Бээжингийн нэмэлт, өөрчлөлт(1999) Монреалын протоколын талуудын 11 дүгээр хурлаар баталсан Монреалын протоколд оруулсан нэмэлт, өөрчлөлт | 1999.11.29-12.03 | 2001.01.01 | 2007.10.18 | 2008.06.24 |
| 19. | Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц | 2001.05.22 | 2004.05.17 | – | 2004.04.30 |
| 20. | Ургамал хамгааллын тухай Ромын конвенц | 1951.12.06 | 1952.04.03 | 2008.10.09 | 2009.05.26 |
| 21. | Антрактидийн тухай гэрээ | 1959.12.01 | 1961.06.23 | 2015.03.23 | 2015.03.23 |
| 22. | “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь Конвенцийн Парисын хэлэлцээр” | 2015.12.12 | | 2016.04.22 | |
| 23. | “Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тухай Конвенц | 1998.06.25. | | | |

Хүснэгт 6. Монгол Улсын бусад улс орнуудтай байгуулсан хоёр талт хэлэлцээр

| № | Хэлэлцээр байгуулсан улс, төрийн байгууллага | Хэлэлцээр байгуулсан хугацаа, газар |
|---|--|-------------------------------------|
| 1 | Байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНКаЗУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр | 1998.03.12 Алмата |
| 2 | БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр | 1990.05.06 Улаанбаатар |
| 3 | Монгол Улсын Засгийн газар, БНКаЗУ-ын Засгийн газар хооронд ургамлын хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр | 1998.03.12 Алмата |
| 4 | Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр | 1994.02.15 Улаанбаатар |

Зураг 6. Монгол Улсын нэгдэн орсон олон талт болон хоёр талт олон улсын гэрээ, конвенц (хувиар)



Зарим олон улсын конвенцуудаас дурдвал, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)³, Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг, ялангуяа усны шувуу олноор амьдардаг орчны тухай конвенц (Рамсарын конвенц), Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (Бонны конвенц), Биологийн олон янз байдлын тухай конвенц (1993) зэргийг дурдаж болохоор байна.

³ Дэлхийн байгаль хамгаалах сангаас эрхлэн бэлтгэсэн “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн лавлах (Улаанбаатар, 2018 он)-аас үзнэ үү.

Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг, ялангуяа усны шувуу олноор амьдардаг орчны тухай конвенцоор Хэлэлцэн тохирогч тал бүр ус, намгархаг газар болон усны шувуудын хамгаалалтыг сайжруулах үүднээс тухайн газар жагсаалтад орсон эсэхээс үл хамааран тэдгээрийг байгалийн нөөц газар бий болгон зохих хамгаалалтаар хангахад оршино. Ус намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц нь Каспийн тэнгисийн өмнөд эрэг дээр орших Иран улсын Рамсар хотод 1971 оны 3 дугаар сарын 02-ны өдөр байгуулагджээ. Ийнхүү тус конвенц нь Рамсарын конвенц нэрээрээ дэлхий дахинд нэрлэгдэж ирсэн байна.

1998 оны 6 дугаар сарын 05-ны өдөр УИХ-аас Рамсарын конвенцид нэгдэн орох тухай хууль батлан гаргасан бөгөөд манай улс уг конвенцид 1998 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр албан ёсоор нэгдэн орсон. Уг конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдон конвенцийн Монголын үндэсний хороог байгуулан ажиллаж байна. Тус конвенцид нийт 11 ус намгархаг газар бүртгэгдээд байна.

Биологийн олон янз байдлын тухай конвенцод Монгол Улс 1992 оны 6 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурж, 1993 оны 6 дугаар сарын 01-ний өдөр УИХ-аар соёрхон баталж, 9 дүгээр сарын 30-ны өдөр нэгдэн орсон байна. 1993 оны 12 дугаар сарын 29-ний өдөр тус конвенц нь хүчин төгөлдөр болсон байна. Энэхүү Конвенцийн зорилго нь түүнд туссан заалтуудын дагуу биологийн төрөл зүйлийг хамгаалах, түүний бүрэлдэхүүн хэсгийг тогтвортой ашиглах, генетикийн нөөцийг ашиглуулах, холбогдох технологийг дамжуулж эзэмшүүлэх, санхүүжүүлэх замаар уг нөөцийг эрхзүйн дагуу шударга тэгш үндсэн дээр хамтран үр ашигтай ашиглах явдал юм.

Конвенцийн хэрэгжилтийн хүрээнд Биоаюулгүй байдлын Картагены протоколыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Биоаюулгүй байдлын асуудлыг зохицуулах Үндэсний гүйцэтгэх хорооны бүрэлдэхүүн”, “Биоаюулгүй байдлын асуудлыг зохицуулах Үндэсний гүйцэтгэх хорооны дүрэм”, “Амьд хувиргасан организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг улсын хэмжээнд хянаж, бүртгэх журам” болон Засгийн газрын тогтоолын төслүүдийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар боловсруулжээ.

2.3

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Энэ судалгааны ажлын чиглэлээр 1990 онд БНМАУ, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгаль орчныг хамгаалах талаар хэлэлцээрийг баталсан байдаг. Мөн Монгол Улсын Засгийн газраас тухайн чиглэлийн сайд дангаараа болон бусад яамны сайдуудтай хамтран 28 тушаалыг батлан гаргажээ.

Монгол Улс Үндсэн хуульдаа хүрээлэн буй орчны талаарх эрх зүйн зохицуулалтыг нэлээд тусгаж, улмаар амьтан, ургамал төрийн хамгаалалтад байхыг хуульчилсан байдаг. Дэлхий нийтийн даяаршилтай холбогдон Монгол Улс хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр олон улсын олон талт гэрээнд нэгдэн орсоор байна. Ийнхүү тухайн олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон улс болгон тухайн конвенцийн хэрэгжилтийн талаар тогтмол тайлагнаж, улмаар өөрийн орны хууль тогтоомждоо тусгах үүрэг хүлээдэг. Энэхүү үүргээ Монгол Улс хангалттай биелүүлж байгаа хэдий ч түүний хэрэгжилтийг хангах тал дээр анхаарал хандуулах шаардлагатай байна.

Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тухай Конвенцид нэгдэн орох шаардлага, хэрэгцээ бий болжээ. Учир нь иргэд хүрээлэн буй орчны талаар хэрхэн мэдээлэл авах, зөрчигдсөн тохиолдолд хаана хандах талаар мэдлэг сул байгаа нь шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэргийн материалаас харагдаж байна.

Шүүхээр шийдвэрлэгдэж байгаа болон цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа хэргийн материал, сэжигтэн, шүүгдэгч нарын мэдүүлгээс харвал, тэдний хүрээлэн буй орчны хууль тогтоомжийн талаарх мэдлэг сул, мэдээ мэдээлэл ховор байгаа нь ажиглагдаж байна. Иймд иргэдийн дунд хүрээлэн буй орчин болон амьтан, ургамлыг хайрлан хамгаалах мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, эрхзүйн акт баримт бичгийг сурталчлан таниулах шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газраас хууль тогтоомжийн хийдэл, давхардал, алдаа зөрчилдөөнийг арилгах зорилгоор хэд хэдэн үе шат бүхий аргачлалыг

боловсруулж, түүний дагуу үйл ажиллагаа явуулсны үндсэн дээр 2012 онд УИХ-аас Байгаль орчны багц хуулиудыг баталсан билээ. Энэхүү ажлын хүрээнд Монгол Улс хэд хэдэн олон улсын гэрээ конвенцид нэгдэн орж амьтан, ургамлын талаарх эрх зүйн орчинд томоохон өөрчлөлт оржээ.

Засгийн газар 2012 оноос эхлэн байгаль орчны багц хуулиудыг шинэчлэх ажлыг зохион байгуулж, 30 гаруй хуулийн 500 гаруй давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, ижил төстэй 18 хуулийг 8 болгон нэгтгэж, 2 хуулийг шинээр боловсруулан батлуулсан байна. Багц хуульд байгалийн нөөцийг хомсдуулсан орон нутаг хариуцсан Засаг даргад хариуцлага тооцох, бохирдуулагч нь төлбөр төлөгч байх, ашиглагч нь хамгаалагч байхаар зохицуулсан нь зарчмын цоо шинэ, томоохон өөрчлөлт орсон байна.

Байгаль орчныг хамгаалах багц хууль тогтоомжийн үйлчлэх хүрээ хязгаараар авч үзвэл, эрх зүйн орчин хангалттай сайн бүрдсэн хэдий ч зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах зэрэг ажил тасралтгүй хийгдэж байгаа ч хэрэгжилт тун хангалтгүй байсаар байна.







ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛС, ОХУ, БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ТЭДГЭЭРИЙН ХАРЬЯА ЯАМ, АГЕНТЛАГУУДЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ, ЯЛАНГУЯА ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУУЛЬ БУС ХУДАЛДАА, АГНУУРТАЙ ХОЛБООТОЙ ЗҮЙЛ, ЗААЛТУУД ТУСГАГДСАН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭРИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ”¹ гэж заажээ.

2016 оны Олон Улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн **5 дугаар зүйлд зааснаар** “.....Олон улсын гэрээг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, тухайн гэрээний үндэслэл, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн байгуулна”, “.....Монгол Улсын олон улсын гэрээг Монгол Улсын нэрийн өмнөөс улс хоорондын болон Засгийн газрын нэрийн өмнөөс Засгийн газар хоорондын түвшинд байгуулна. Монгол Улсын Засгийн газар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газар хоорондын олон улсын гэрээ байгуулах эрхтэй”, “.....Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлаар энэ хуульд заасны дагуу Засгийн газраас олон улсын гэрээ байгуулах эрх авсны үндсэн дээр Засгийн газрын нэрийн өмнөөс Засгийн газар хоорондын олон улсын гэрээ байгуулж болно” хэмээн тус тус заасан байдаг.

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотноо болсон Шанхайн Хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 16 дугаар хуралдааны үеэр Монгол, Орос, Хятад улсын төрийн тэргүүнүүдийн гурав дахь дээд хэмжээний уулзалт амжилттай болж 2015 онд байгуулсан Санамж бичгүүдийн хүрээнд тодорхой баримт бичгүүдэд гарын үсэг зурж, ажил хэрэг болгох алхмыг хийсэн байна.

Тодруулбал, Монгол-Орос-Хятадын хооронд Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр, Зарим нэр төрлийн бараанд хийсэн гаалийн хяналтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрт тус тус гарын үсэг зурсан нь гурван талын хамтын ажиллагааг бодит агуулгаар баяжуулж, шинэ шатанд гаргахад чиглэсэн чухал арга хэмжээ болсон байна.

Узбекистаны нийслэл Ташкент хотноо болсон Монгол, БНХАУ, ОХУ-ын төрийн тэргүүнүүдийн гурван талт уулзалтын үеэр (2016 оны 6 дугаар сарын 23-ны өдөр) гурван улсыг холбосон “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийг баталжээ. Тус хөтөлбөрийн хүрээнд хүрээлэн буй орчныг хамгаалах болон экологийн чиглэлээр:

- Байгалийн тусгай хамгаалалттай газар нутгийн чиглэлээр гурван талын харилцан ашигтай хамтын ажиллагааг хангах практик хамтын

1 [http://www.mfa.gov.mn/?page_id=25999//Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал/](http://www.mfa.gov.mn/?page_id=25999//Монгол%20Улсын%20Гадаад%20бодлогын%20үзэл%20баримтлал/) Монгол Улсын Их Хурлын тогтоол. Дугаар 10. 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр. Улаанбаатар хот

ажиллагааг эрчимжүүлэх, холбогдох харилцаа холбоог бэхжүүлэх, зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулах, Монгол, Орос, Хятадын хамтарсан “Дагуурын дархан цаазат газар”-ын үйл ажиллагааны хүрээнд харилцан ашигтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх,

- Монгол, Орос, Хятадын хил дамнасан экологийн коридоруудыг байгуулах, зэрлэг ургамал болон амьтны аймаг, ус, намгархаг газартай холбогдох эрдэм шинжилгээний хайгуул, хяналт шинжилгээ хийж, зэрлэг ан амьтан, ургамал, нүүдлийн шувуудыг хамгаалах салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх,
- Хүрээлэн буй орчныг хамгаалах болон экологийн салбарт хамтарсан удирдлагын болон мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох боломжийг судлах, түүнчлэн байгаль орчныг хамгаалах чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэхээр тогтсон байна.

Энэхүү “Эдийн засгийн коридор байгуулах” төслийн хэтийн төлөв нь гурван улсын улс төр, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх стратегийн түншлэлийн суурийг тавиад зогсохгүй, байгаль орчин, түүний дотор зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах стратеги зорилгыг тодорхойлсонд оршино. Жишээ нь 1994 оны 3 дугаар сарын 29-ны өдөр гурван талын хил дамнасан Олон улсын Дагуурын дархан газар байгуулах тухай хэлэлцээрт гарын үсэг зурснаар Монгол-ОХУ-БНХАУ-ын хамтарсан 1,725,220 га газар нутаг бүхий олон улсын Дагуурын дархан газар байгуулагджээ, Дагуурын Дархан цаазат газрын 3 улсын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд ОХУ-ын Даурскын дархан газар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Далай нуурын тусгай хамгаалалттай газар, Монгол Улсын Монгол-Дагуурын Дархан цаазат газар хамаарна.

2010 онд манай улсын Дорнод аймгийн Чойбалсан хотноо гурван улсын Дархан цаазат газрын Хамтын ажиллагааны 5 дугаар хурал зохион байгуулагдаж Хамтын ажиллагааны дүрэм, 2010-2015 оны төлөвлөгөө зэргийг хэлэлцсэн байна. Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хайлаар хотноо 2015 оны 12 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд 6 дугаар хурал зохион байгуулагдаж Хамтын ажиллагааны дүрмийг баталгаажуулж, 2011-2015 оны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, 2016-2020 оны төлөвлөгөө зэргийг баталжээ.

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах, дэмжиж ОХУ, БНХАУ, Монгол Улсад Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF), НҮБХХ, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS) зэрэг байгууллагууд тодорхой хэмжээнд төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь зэрлэг амьтан, ургамлыг хамгаалах гурван улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлж хөгжүүлэхэд чухал хувь нэмэр болж байна.

3.1

ЗЭРЛЭГ УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМГИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЯАМ, АГЕНТЛАГУУДЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ХОЁР ТАЛТ ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭР, АКТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улс нь БНХАУ-тай 4,709,658 км, үүнээс хуурай газраар 4,488.6 км, усаар 221.158 км хиллэдэг. БНХАУ, Монгол Улсын хил залгаа бүс нутагт Хятадын талаас Өвөр Монголын Өөртөө засах орон, Шиньжян-Уйгурын Өөртөө засах орон хоёр, Монголын талаас Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий зэрэг нийт 6 аймаг хиллэдэг.

Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1949 оны 10 дугаар сарын 16-ны өдөр дипломат харилцаа тогтоожээ. Хоёр тал 1950 онд Улаанбаатар, Бээжин хотноо тус тус Элчин сайдын яамаа харилцан нээсэн. Монгол Улс 1991 онд ӨМӨЗО-ны Хөх хотод Консулын газраа сэргээн байгуулж, 1996 онд түүний салбарыг Эрээн хотод нээсэн бөгөөд 2007 онд Консулын бие даасан газар болгон ажиллуулах болжээ. Мөн 2011 онд Монгол Улсаас БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгт Консулын газар, 2012 онд БНХАУ-ын Шанхай хотод Консулын төлөөлөл, 2014 онд ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хотод Консулын газар тус тус байгуулж, үйл ажиллагаа явуулж байна.

1949-1962 онд хоёр талын харилцаа шинээр төлөвшин хөгжиж, энэ хугацаанд Найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ (1960 он), Хилийн гэрээ (1962 он) зэрэг хоёр орны харилцааны эрх зүйн үндэс суурийг тавьсан олон гэрээ байгуулагджээ. 1994 онд Монгол Улс, БНХАУ-ын хооронд Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг шинэчлэн байгуулсан. Энэхүү гэрээ нь хоёр улсын одоогийн харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлжээ.

1949-2018 онд хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлуудыг зохицуулсан 400 гаруй гэрээ байгуулагдсанаас 151 гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна.

Нэг. Байгаль орчныг хамгаалах салбарт Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газрын хооронд дараах гэрээ хэлэлцээрийг байгуулан мөрдөж байна. Үүнд:

- 1.1. БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ. Улаанбаатар (1989 оны 8 дугаар сарын 31-ний өдөр)
- 1.2. БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр. Улаанбаатар (1990 оны 5 дугаар сарын 06-ны өдөр)
- 1.3. БНМАУ-ын Хууль зүйн яам, БНХАУ-ын Хууль зүйн яам хоорондын хамтран ажиллах тухай протокол. Улаанбаатар (1991 оны 7 дугаар сарын 04-ний өдөр)
- 1.4. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын ургамлын хорио цээрийн тухай хэлэлцээр. Бээжин (1992 оны 5 дугаар сарын 09-ний өдөр)
- 1.5. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд мал, амьтны хорио цээр болон мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр. Улаанбаатар (1994 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр)
- 1.6. Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай Монгол Улс, БНХАУ хоорондын гэрээ. Улаанбаатар (1997 оны 8 дугаар сарын 19-ний өдөр)
- 1.7. Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон БНХАУ хоорондын гэрээ. Бээжин (2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр)
- 1.8. Гэмт хэрэгтэй хамтран тэмцэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээр. Улаанбаатар (2011 оны 7 дугаар сарын 07-ны өдөр)
- 1.9. Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1949-2012 онд байгуулсан хоёр талт гэрээний үйлчлэлийн талаарх Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын протокол. Улаанбаатар (2014 оны 8 дугаар сарын 21-ний өдөр)

Хоёр. Монгол Улс, БНХАУ хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөрийг 2013 онд батлан хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд байгаль орчин, биологийн төрөл зүйл, хилийн усыг хамгаалах чиглэлийн хамтын ажиллагааг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- 2.1. Талууд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын ажиллагаагаа урагшлуулж, хамтын эрх ашгийг хамгаална.
- 2.2. Талууд байгаль хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаагаа нэмэгдүүлж, экологи, биологийн төрөл зүйлийг хамгаалах асуудлыг эрчимжүүлж, шар шороон шуурга, цөлжилтөөс сэргийлэх, хяналт тавих, байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, хот, тосгодын хүрээлэн буй орчны менежмент, байгаль орчны талаарх иргэдийн

боловсрол ба мэдлэг, байгаль орчныг хамгаалах чадавх зэрэг чиглэлээрх хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.

2.3. Талууд Монгол, Хятадын хил дамнасан байгаль орчны хамтын ажиллагаа болон хилийн усны хамтарсан комиссын механизмыг бэхжүүлэн, боловсронгуй болгож, хилийн усыг зүй зохистой ашиглах, хамгаалах чиглэлээрх нягт хэлхээ холбоо, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ.

2.4. Талууд байгаль орчны асуудлаарх мэдээллийг харилцан солилцох ажлыг эрчимжүүлж, мэргэжилтэн, судлаач, төлөөлөгчдийн харилцан айлчлалыг нэмэгдүүлж, эрдэм шинжилгээний болон удирдах ажилтан, холбогдох бусад мэргэжилтнийг оролцуулсан семинар, тусгай сэдэвт хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулна.

2.5. Талууд мазаалай зэрэг зэрлэг амьтан, ургамлыг хамгаалах чиглэлд хамтран ажиллах асуудлыг идэвхтэй судална.

Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх энэхүү хөтөлбөр нь мазаалай зэрэг зэрлэг амьтан, ургамлыг хамгаалах чиглэлд хамтран ажиллах асуудлыг идэвхтэй судлах, хамтарсан төлөвлөгөө хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх, судлах, сурталчлах хамтын ажиллагааны хэтийн төлөвийг нээсэн чухал арга хэмжээ болсон байна. Тухайлбал, 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Монгол Улсад мазаалайг хамгаалах чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэх төсөл хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт гарын үсэг зурах ёслол Улаанбаатар хотноо амжилттай болж өндөрлөжээ.

2.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар БНХАУ-ын дарга Си Зиньпин 2014 оны 8 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Монгол Улсад төрийн айлчлал хийсэн бөгөөд айлчлалын үеэр БНХАУ-ын дарга Си Зиньпин Улаанбаатар хотноо Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой хэлэлцээ хийж, УИХ-ын дарга З.Энхболд, Ерөнхий сайд Н.Алтанхуяг нартай тус тус уулзав. Хоёр улсын удирдагчид найрсаг, элэгсэг дотно уур амьсгалд хоёр улсын харилцааны болон харилцан сонирхсон олон улс, бүс нутгийн өргөн хүрээний асуудлаар санал солилцож, олон чухал тохиролцоонд хүрч, “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал” гаргаж, түүнчлэн Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны түвшинг дээшлүүлэн Монгол, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоохоор санал нэгтгэйгээр тохиролцжээ.

Энэхүү тунхаглалд “Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого, БНХАУ-ын экологийн соёл иргэншлийн бүтээн байгуулалтын хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлж, талууд цаашид цөлжилт болон уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэл, ой хээрийн

түймэртэй тэмцэх, усны нөөцийг ашиглах болон хамгаалах зэрэг салбарын хамтын ажиллагааг бэхжүүлнэ” хэмээн тусгажээ.

Мөн “Талууд хоёр талын хууль сахиулах байгууллагууд, түүний дотор хил хамгаалах, цагдаа, авлигатай тэмцэх зэрэг байгууллага хоорондын өндөр түвшний харилцаа, хамтын ажиллагааны механизмыг хөгжүүлэн бэхжүүлэх, хамтран ажиллах, талууд терроризм, хил дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын хууль бус наймаа, хүний наймаатай хамтран тэмцэх, урьдчилан сэргийлэх зэрэг чиглэлийн хамтын ажиллагаагаа бэхжүүлэхээр тохиролцсон”² байна.

- 2.7. 2011 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хотноо гарыг үсэг зурсан “Гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 5 дугаар зүйлд зааснаар “...гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр өөрсдийн эрх мэдлийн хүрээнд тус тусын нутаг дэвсгэрт гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг болон гэмт хэрэгтнийг эрэн сурвалжлах, баривчлах, мөрдөн шалгах ажлыг зохион байгуулж, тухайн этгээдийн хэн болох, хэргийн нотлох баримт болон хэргийн талаар мэдэгдэн эдгээр этгээдийг нөгөө Талд шилжүүлэн өгөх арга хэмжээ авна” гэж заажээ. Түүнчлэн тус хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасан “үндэстэн дамнасан бусад гэмт хэрэг”-ийн хүрээнд зэрлэг амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллах боломж нээлттэй байна.

Гурав. 1990 оны 5 дугаар сарын 06-ны өдөр БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг Улаанбаатар хотод үзэглэжээ. Энэхүү гэрээ нь Олон Улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлд заасан Олон улсын гэрээ байгуулах түвшин, эрх бүхий этгээдийн бүрэн эрхийн хууль зүйн шаардлагыг хангасан байна. Энэ гэрээнд аль нэг тал нь цуцлах өөрчлөх санал гаргаагүй бол тав таван жилээр сунгагдан хэрэгжихээр тусгасан байна.

Хэдийгээр, энэхүү гэрээг өнгөрсөн зууны 90-ээд онд байгуулсан ч агуулга, хэлбэр, хамрах хүрээний хувьд 2016 оны Олон Улсын гэрээний тухай Монгол Улсын хуульд заасан зарчим, түвшин, агуулга хэлбэрийг бүрэн тусгасан, олон улсын эрх зүйн ач холбогдолтой хэвээр байна.

Дөрөв. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам хооронд хамтран ажиллах, харилцан ойлголцлын санамж бичгийг 2011 оны 12 дугаар сарын 13-ны өдөр үзэглэжээ. Энэхүү

² <http://www.president.mn/mongolian/node/4116>

санамж бичиг нь Гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Талууд хэрэгжүүлэх болон түүнд үндэслэн хууль сахиулах чиглэлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилготой байна.

Эдгээр баримт бичгийг үндэслэн Хамтран ажиллах тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам хоорондын 2017-2021 үйл ажиллагааны хөтөлбөрийг 2017 оны 5 дугаар сард Бээжин хотноо баталжээ. Энэ баримт бичигт хамтарсан чиглэлээр айлчлал, мэдээлэл, сургалт хамтран зохион байгуулах, оюутан, профессор солилцох, техник хэрэгслийн туслалцаа үзүүлэхээр заажээ.

2010 онд Улаанбаатар хотод байгуулсан **Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээний** 11 дүгээр зүйлд зааснаар “Хоёр талын иргэд хилийн усны өөрийн талд загасны аж ахуй эрхэлж болно. Тэсэрч дэлбэрэх, хорт бодис, цахилгаан гүйдэл зэргийг ашиглаж загас, усны бусад амьтан барихыг хориглоно. Шинжлэх ухаан, судалгааны зорилгоор ашиглахаас бусад тохиолдолд загасчлах хориотой хугацаа, бүсэд загас, усны бусад амьтан агнахыг хориглоно. Хилийн усанд загасны аж ахуй эрхлэх үйл ажиллагаа нь хөвөх хэрэгслийн зорчих хөдөлгөөнд саад учруулах ёсгүй. Талуудын эрх бүхий байгууллага хилийн усны загасны нөөцийг зүй зохистойгоор ашиглах, хамгаалах, нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана. Түүнчлэн хилийн усны загас, усны бусад амьтдыг хамгаалж, үржүүлэх асуудлыг Талуудын эрх бүхий байгууллага хэлэлцээ хийж шийдвэрлэнэ”³ гэжээ.

Мөн баримт бичгийн 19 дүгээр зүйлд “Талууд хилийн шугамаас хоёр тийш 1000 метрийн зай дотор ан агнах, буудах, хил давуулан буудах, ан амьтан хөөхийг хориглоно. Талууд ан амьтан хил даван нүүдэллэхэд зориудаар саад учруулж болохгүй. Хэрэв хилийн байгууламж нь ан амьтны нүүдэлд нөлөөлж байвал Талууд хэлэлцэн шийдвэрлэнэ” гэжээ.

Баримт бичгийн 20 дугаар зүйлд зааснаар “Талууд хил орчмын нутгийн тодорхой хэсэгт харилцан тохиролцсоны үндсэн дээр хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг байгуулж болно. Талууд болон Талуудын эрх бүхий байгууллага энэ талаар холбогдох хэлэлцээр байгуулж болно”. Мөн 24 дүгээр зүйлд “Талууд хил зөрчих, хил орчмын нутагт хууль бусаар оршин суух, хөдөлмөр эрхлэх, контрабанд хийх, хар тамхи, мансууруулах бодис, хориотой барааг худалдах, тээвэрлэх зэрэг хил дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтран тэмцэхэд чиглэсэн хамтын ажиллагаагаа бэхжүүлнэ.

3 <http://www.legalinfo.mn/law/details/1148?lawid=1148>

Талууд болон Талуудын эрх бүхий байгууллага энэ талаар холбогдох хэлэлцээр байгуулж болно” хэмээн тусгасан байна.

Баримт бичгийн 31 дүгээр зүйлд зааснаар талуудын хилийн төлөөлөгч болон эрх бүхий байгууллага дараах хилийн зөрчлүүдээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх чиглэлээр хамтран ажилладаг байна. Тухайлбал;

- 1) Хууль бусаар хил нэвтэрч аж ахуй эрхлэх, байгалийн баялаг эрэх, хайх, олборлох, ан агнах болон бусад үйл ажиллагаа эрхлэх;
- 2) Хүн, барааг хууль бусаар хилээр нэвтрүүлэх;
- 3) Хар тамхи, мансууруулах бодис, зэвсэг, галт хэрэгсэл зэргийг хууль бусаар хилээр нэвтрүүлэх зэрэг болно.

Үүнээс үзэхэд, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Хил хамгаалах ерөнхий газар нь БНХАУ, ОХУ-ын хил хамгаалах байгууллагуудтай хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдаа, ан агнууртай холбоотой гэрээг өнөө хүртэл тусгайлан байгуулаагүй байгаа нь учир дутагдалтай байна.

Тав. 2017 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо “Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Эрүүгийн цагдаагийн алба болон БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхим хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт хоёр тал гарын үсэг зурсан байна. Энэхүү санамж бичигт тодорхой төрлийн зарим гэмт хэргийн талаар мэдээлэл, туршлага солилцох агуулгатай байгаа боловч зэрлэг ургамал, амьтны аймгийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтран тэмцэх талаар тусгайлсан заалт үгүй байна. Харин баримт бичгийн утга агуулгаар Санамж бичгийн хоёрдугаар зүйл “Хамтын ажиллагааны ерөнхий нөхцөл”-ийн 2.1.11 дэх “бусад” гэдэг заалтын хүрээнд ойлгож болохоор байна.

Товч дүгнэхэд, хоёр улсын нийгэм-улс төр, эдийн засгийн тогтолцоо, эдгээр байгууллагуудын ажлын онцлог байдал зэргээс шалтгаалж гэмт хэрэг, түүний дотор зэрлэг ургамал, амьтны эсрэг гэмт хэрэгтэй хамтран тэмцэх практик алхам хийгдээгүй байна. Гэсэн хэдий ч энэ чиглэлээр цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж бүрэн байна.

Мөн 1990 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр БНМАУ-ын Байгаль орчны яам, БНХАУ-ын Байгаль орчныг хамгаалах газрын хооронд хоёр орны байгаль орчныг хамгаалах хамтын ажиллагааг явуулах тухай санамж бичгийг үзэглэжээ. Хэдийгээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэдий ч санамж бичгийн хэлбэр, агуулга, үзэл санаа нь ихээхэн хуучирсан, үйлчлэл нь зогссон шинжтэй байна.

Зургаа. *“Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 1993 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулснаар Монгол, Хятадын гаалийн хамтын ажиллагааны суурь тавигджээ. Энэ цагаас хойш хоёр орны хамтын ажиллагаа Засгийн газар болон гаалийн байгууллагуудын хооронд байгуулагдсан хэлэлцээр, протокол, санамж бичиг, төлөвлөгөө зэрэг үндсэн баримт бичгүүдээр зохицуулагдаж байна.*

Монгол-Хятадын гаалийн байгууллагын дарга болон дэд дарга нарын уулзалтыг 2014 онд 2 удаа Монгол Улсад болон БНХАУ-д, 2016 онд Монгол Улсад зохион байгуулж, дээрх үндсэн баримт бичгийн хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улс, БНХАУ-ын гаалийн «Хилийн хамтарсан шалгалт»-ын ажлын хэсгийг анх 2006 онд байгуулж, 8 удаагийн уулзалтыг зохион байгуулж, манифестийн мэдээллийг цаасаар болон цахим хэлбэрээр солилцох, ачааны рентген зураг солилцох, үүнтэй уялдуулан манифестийн мэдээллийг ижилтгэх, цахим хэлбэрээр мэдээлэл солилцохтой холбоотой технологийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зэрэг олон үйл ажиллагааг хамтран зохион байгуулж иржээ. “Хилийн хамтарсан шалгалт”-ын ажлын хэсгийн сүүлийн 3 хуралдааныг ГЕГ-ын чиглэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж талуудтай хамтран амжилттай зохион байгуулж, гаалийн хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газар болон БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын Гаалийн цагдаагийн газар 2017 оны ... дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатар хотноо үзэглэсэн “Гаалийн асуудлаар 2018-2019 онд хамтран ажиллах төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна.

Төлөвлөгөөний дагуу хоёр тал хийж гүйцэтгэх нэг үндсэн чиглэл нь “..мөхөж ховордсон амьтан, ургамал болон түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг хилээр хууль бусаар тээвэрлэх, худалдаалах зэрэг хил дамнасан гэмт хэргийн шинжтэй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах” арга хэмжээг тусгажээ.

Энэ хүрээнд зэрлэг амьтан, ургамлын ховордсон төрөл, зүйлийн хууль бус худалдааны талаар дараах мэдээллийг солилцдог байна. Үүнд:

- 1) хүн, хуулийн этгээдийн мэдээлэл;
- 2) хэрэг зөрчлийн мэдээлэл;
- 3) тээвэрлэлтийн мэдээлэл зэрэг байна.

Мөн талууд хил дамнасан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр хамтарсан ажиллагаа зохион байгуулах хүрээнд тодорхой нэг төрлийн хэрэг зөрчилтэй тэмцэх чиглэлээр талуудын хил залгаа боомтууд дээр нэгдсэн удирдлага, төлөвлөгөө бүхий хамтарсан ажиллагааг 2019 оноос зохион байгуулахаар тусгасан нь байгаль орчин, зэрлэг ургамал, амьтны аймгийн эсрэг гэмт явдалтай тэмцэх хамтын ажиллагааны нэг шинэ хуудас нээсэн хэрэг болж байна.

Түүнчлэн Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хооронд хууль бусаар хил давуулан худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг 2018 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр Бээжин хотноо үзэглэжээ.

Тус харилцан ойлголцлын санамж бичгийн нэг агуулга нь 1993 онд Улаанбаатар хотноо байгуулсан Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, 2010 оны 6 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай 1993 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын протокол, 2011 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан “Гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр зэргийг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцжээ.

Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн зорилго нь “Талууд... хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх хамтын ажиллагаагаа бэхжүүлж, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, мөрдөн байцаах, хууль бусаар хил давуулан худалдах чиглэлээр туршлага солилцох, гаалийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулахад оршиж байна.

Үүнээс үзвэл, гаалийн хамтын ажиллагааны үндсэн гол баримт бичиг нь 20 гаруй жилийн өмнө батлагдсан боловч түүнийг ажил хэрэг болгох хэрэгжүүлэх талаар аль ч тал нэг их санаачилга гаргаагүй нь харагдаж байна. Жишээ нь Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1993 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай асуудлаар 2010 онд протокол үйлдэж байгаа нь үүний тод жишээ мөн. Харин 2017 оноос хамтын ажиллагааны хүрээ өргөжиж байгаа нь туйлын сайшаалтай байна.

3.2

ЗЭРЛЭГ УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМГИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР МОНГОЛ УЛС, ОХУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЯАМ, АГЕНТЛАГУУДЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ХОЁР ТАЛТ ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭР, АКТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улс нь Оросын Холбооны Улстай уламжлалт сайн хөршийн харилцааг хөгжүүлсээр ирсэн байна. Монгол Улсын Ардын Засгийн газар, Зөвлөлт Оросын Засгийн газрын хооронд найрсаг харилцаа тогтоох тухай гэрээг 1921 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр байгуулж, дипломат харилцаа тогтоосон байдаг. Хоёр улс 1922 онд Элчин сайдын яамдаа Улаанбаатар, Москвад харилцан нээсэн байна.

Монгол Улс нь ОХУ-тай 3543 км газраар хиллэдэг бөгөөд үүнээс хуурай газраар 2860 км, усаар 683 км тус тус хиллэдэг байна. Монгол Улс нь ОХУ-ын Өвөр Байгалийн хязгаар, Буриад, Тува, Алтайн Бүгд Найрамдах Улсуудтай хил залган оршдог бол Монголын талаас Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгууд хиллэж байна.

Дипломат харилцаа тогтоосноос хойш Монгол, Оросын харилцаа, хамтын ажиллагаа улс төр, батлан хамгаалах, зам тээвэр, эрдэс баялаг, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, соёл боловсрол, эрүүл мэндийн салбаруудад идэвхтэй хөгжиж ирсэн бөгөөд өндөр, дээд түвшний айлчлалыг тогтмол зохион байгуулсаар байна.

Хоёр улс 2009 оноос Стратегийн түншлэлийг хөгжүүлж эхэлснээр Монгол Улс стратегийн түншлэлийн харилцааг хамгийн анх удаа ОХУ-тай тогтоожээ. Үүнээс хойш Байгаль орчныг хамгаалах, түүний дотор амьтан, ургамлыг хамгаалахтай холбоотой дараах хоёр талын гэрээ хэлэлцээрийг байгуулан мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- 1) Гаалийн асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Москва (1993 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр)

- 2) Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Москва (1993 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр)
- 3) Ургамал хамгаалал, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Улаанбаатар (1993 оны 6 дугаар сарын 29-ний өдөр)
- 4) Байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Москва (1993 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр)
- 5) Ургамал хамгаалал, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Москва (1993 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр)
- 6) Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр. Улаанбаатар (1994 оны 2 дугаар сарын 15-ны өдөр)
- 7) “Хилийн боомт болон Монгол-Орос улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай” Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Улаанбаатар (1994 оны 8 дугаар сарын 10-ны өдөр)
- 8) Монгол Улс, Бүгд Найрамдах Буриад Улсын Эдийн засаг, хил орчмын хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр. Улаанбаатар (1998 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр)
- 9) Монгол Улс, Бүгд Найрамдах Буриад Улсын эдийн засаг, хил орчмын хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Улаанбаатар (1999 оны 2 дугаар сарын 25-ны өдөр)
- 10) Монгол Улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ. Улаанбаатар (1999 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр)
- 11) Монгол Улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ (протоколын хамт). Москва (1999 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр)
- 12) Монгол Улсын орон нутгийн засаг захиргаа болон ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллагын хоорондын хамтын ажиллагааны зарчмуудын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр. Улаанбаатар (2000 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр)
- 13) Монгол Улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай 1999 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн гэрээний протокол. Улаанбаатар (2002 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр)
- 14) “Монгол-Орос улсын хилийн дэглэмийн тухай” Монгол Улс болон

- Оросын Холбооны Улс хоорондын гэрээ. Улаанбаатар (2006 оны 12 дугаар сарын 08-ны өдөр)
- 15) Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Москва (2008 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр)
- 16) Увс нуурын хотгор хил дамнасан дархан газар байгуулах тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Москва (2015 оны 5 дугаар сарын 31-ний өдөр).

1994 онд баталсан Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрт заасан хамтын ажиллагааны нэг үндсэн чиглэл нь “Байгаль орчныг хамгаалах урт хугацааны хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, ургамал, амьтны аймгийг хамгаалах, судлах, түүний дотор ховор болон устаж үгүй болж байгаа дүрс зүйлийг нөхөн сэргээх, арга хэмжээг авах” гэж заажээ.

1994 онд баталсан Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр нь 2016 оны Олон Улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлд заасан олон улсын хоёр талт гэрээний хууль зүйн техникийн болон агуулгын стандартыг бүрэн хангасан байна.

Монгол Улс болон ОХУ хоорондын хилийн хууль бус худалдааны эсрэг авах арга хэмжээ нь Монгол Улс болон ОХУ-ын хооронд Улаанбаатар хотноо 1999 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр байгуулж, улмаар тус оны 9 дүгээр сарын 12-ны өдөр нэмэлт засвар хийж байгуулсан Эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ, 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай гэрээ зэргээр зохицуулагдаж байна.

Хууль сахиулах байгууллагууд, хил, хилийн боомтын чиглэлийн харилцаа, хамтын ажиллагаа нь 1990-ээд оноос хойш Хилийн боомт болон Монгол-Орос улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын 1994 оны хэлэлцээр, Иргэн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын 1999 оны гэрээ, Монгол-Орос улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс болон ОХУ хоорондын 2006 онд байгуулсан гэрээ, Монгол Улс, ОХУ-ын иргэд харилцан визгүй зорчих тухай 2014 оны гэрээ, Иргэдийг албадан буцаах тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын 2014 оны гэрээ, Монгол Улсын Хууль зүйн яам, ОХУ-ын Хууль зүйн яамны хооронд хамтран ажиллах тухай 2014 оны хэлэлцээр болон мэргэжлийн байгууллага,

агентлагуудын хооронд байгуулсан санамж бичиг, тохиролцоонуудын үндсэн дээр жилээс жилд өргөжин тэлж байна.

Монгол Улс болон ОХУ-ын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд дотроос хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил, амьтан ургамлын хууль бус худалдаа, агнууртай холбоотой харилцааг зохицуулсан дараах эрх зүйн актууд үйлчилж байна. Үүнд:

***Нэг.** “Хилийн боомт болон Монгол-Орос улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай” Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 1994 оны 8 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан байна.*

Тус хэлэлцээрийн⁴ Арван нэгдүгээр зүйлд Улсын хилийг нэг удаа нэвтрэх үнэмлэхийг (а) Хоёр улсын хил орчмын нутаг болон түүний хязгаарын гадна оршин суудаг иргэдэд, (б) Талууд хэлэлцэн тохирсны үндсэн дээр хил орчмын нутагт эрдэм шинжилгээ, худалдаа, тээвэр, аж ахуйн үйл ажиллагаа явуулах буюу байгаль орчны байдалд хяналт тавих хүмүүс, (в) Байгалийн гамшиг буюу бусад онцгой нөхцөл байдал, тухайлбал хүн, мал, тэжээвэр болон зэрлэг амьтдын гоц халдварт өвчин, хөдөө аж ахуйн таримал болон бэлчээрийн ургамлын хортон их хэмжээгээр тархах зэрэгтэй тэмцэхэд нөгөө Талын хил орчмын нутгийн засаг, захиргаа, оршин суугчдад туслалцаа үзүүлэхээр яваа хүмүүст тус тус олгохоор тусгажээ.

Мөн энэ хэлэлцээрийн **Арван дөрөвдүгээр зүйлд** Хоёр талын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт байхдаа тухайн орны хууль тогтоомжийг чандлан сахих, ёс заншлыг нь хүндэтгэх, хүрээлэн байгаа орчныг хамгаалах талаар тогтоосон журмыг биелүүлж, хилийн боомт болон хилийг хялбарчилсан журмаар нэвтрэхэд иргэдэд үнэмлэх олгох үндэслэл, мөн хоёр талын иргэд нөгөө талын нутаг дэвсгэрт байхдаа сахин биелүүлэх хэм хэмжээг тусгажээ.

***Хоёр.** “Монгол-Орос улсын хилийн дэглэмийн тухай” Монгол Улс болон Оросын Холбооны Улс хоорондын гэрээг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байгуулжээ. Тус гэрээний хоёр, гурав, дөрөвдүгээр бүлгүүдэд хүрээлэн буй орчинтой холбоотой дараах харилцааг тусгажээ. Үүнд:*

Энэ гэрээний Хоёрдугаар бүлгийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Холбогдох байгууллага хилийн усыг химийн бодис, хаягдал усаар болон бусад хэлбэрээр хордуулах буюу бохирдуулахгүй байх шаардлагатай арга хэмжээ авна” гэжээ.

⁴ Хил хамгаалах ерөнхий газрын 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 2/10817 дугаар бүхий албан бичгийн хавсралтад дурдсан.

Мөн тус гэрээний Гуравдугаар бүлэгт Хил орчмын нутаг дэвсгэрт аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, байгаль орчныг хамгаалах, гамшигтай тэмцэх ажлын чиглэлийг дараах байдлаар тогтоожээ. Үүнд:

- **17 дугаар зүйлд** (1) Монгол Улс, Оросын Холбооны Улсын оршин суугчид нь өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу зөвхөн улсын хилийн шугам хүртэл загас барьж болно. Энэ үедээ тэсрэх болон хорт бодис хэрэглэх, түүнчлэн загасыг үй олноор хөнөөх, загасны нөөц, усан орчны тэнцвэртэй байдалд хохирол учруулахуйц бусад арга хэрэглэхийг хориглоно. (2) Холбогдох байгууллага нь зэрлэг амьтад (загас, шувуу, сүүн тэжээлтэн), ялангуяа устаж алга болоход хүрсэн ховордсон амьтдыг улсын хилээр чөлөөтэй нүүдэллэхэд саад тотгор учруулахгүй байхад хяналт тавина. (3) Холбогдох байгууллага нь хэлэлцэн тохирогч талуудын дотоодын хууль тогтоомжийн дагуу зэрлэг амьтад (загас, шувуу, сүүн тэжээлтэн), ялангуяа устаж алга болоход хүрсэн ховордсон амьтдыг хамгаалах, үржүүлэх, хил орчмын нутаг дэвсгэрт ан хийх, загас барихыг хориглох асуудлыг зөвшилцөн тохиролцож, ан хийх, загас барих хугацааг тогтооно.
- **18 дугаар зүйлд** (1) Холбогдох байгууллага нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ан агнуурын журмыг өөрийн улсын хил орчмын нутаг дэвсгэрт биелүүлэхэд хяналт тавина. (2) Холбогдох байгууллага нь улсын хилээс хоёр тийш 1000 метрийн бүсэд зэрлэг амьтад (загас, шувуу, сүүн тэжээлтэн)-ыг агнах, түүний дотор галт зэвсэг хэрэглэх, анчид, загасчид, малчдын болон бусад отог байгуулахыг хориглоно. (3) Монгол Улс, Оросын Холбооны Улсын оршин суугчид ан хийхдээ улсын хилийн зүг буудахгүй байх болон зэрлэг амьтад (шувуу, сүүн тэжээлтэн)-ыг улсын хил давуулан мөрдөн хөөхгүй байх үүрэгтэй. (4) Хэлэлцэн тохирогч талууд шаардлагатай бол ан хийх, загас барих, түүнчлэн хил орчмын нутаг дэвсгэрийн зарим хэсэг дархан цаазат газар байгуулахтай холбоотой хамтарсан арга хэмжээ авна.
- **19 дүгээр зүйлд** (4) Холбогдох байгууллага нь улсын хилээр хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын өвчин үүсгэгч болон хөдөө аж ахуйн таримал ургамлын хортон шавьж нэвтрэхийн эсрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Эрх бүхий байгууллага нь дээр дурдсан өвчин болон хортон шавж хил орчмын нутаг дэвсгэрт илэрсэн тухай бие биедээ нэн даруй мэдэгдэнэ. (5) Хэлэлцэн тохирогч талууд хил орчмын нутаг дэвсгэрт ой мод болон байгалийн баялгийг хамгаалах, гамшиг, ойн болон хөдөө аж ахуйн хортон шавжтай тэмцэх, түүнчлэн байгалийн баялгийг ахуйн зорилгоор ашиглах асуудлаар шаардлагатай бол

холбогдох хэлэлцээр байгуулж болно. (6) Хэлэлцэн тохирогч нэг талын хил орчмын нутаг дэвсгэрт байгалийн баялаг олборлох, тэсэлгээний болон газар шороотой холбоотой бусад ажлыг зөвхөн хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллагад хоёроос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэний дараа явуулж болно. Эдгээр ажлыг гүйцэтгэхдээ хэлэлцэн тохирогч нөгөө талын оршин суугчид, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол учруулахгүй байх урьдчилсан арга хэмжээг авсан байх ёстой.

- **20 дугаар зүйлд** Хэлэлцэн тохирогч нэг талын хил орчмын нутаг дэвсгэрт явуулж буй аж ахуйн үйл ажиллагаа нь хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрийн хүрээлэн буй орчинд хортой нөлөө үзүүлэхгүй байх шаардлагатай арга хэмжээ авна.
- Энэ гэрээний Тавдугаар бүлэгт Хилийн бүрэн эрхт төлөөлөгч, түүний эрх, үүргийг тусгажээ. Тухайлбал, 26 дугаар зүйлд Хилийн бүрэн эрхт төлөөлөгч нь өөрийн үйл ажиллагааны хэсгийн хүрээнд (1) Хэлэлцэн тохирогч талуудын холбогдох байгууллагатай хамтран улсын хил дээр болон түүний ойролцоо аж ахуйн ажил, бусад үйл ажиллагаа эрхлэх, түүнчлэн хилийн усны сав газрын ус ашиглах, ан хийх, загас барих журмын хэрэгжилтэд хяналт тавина, (2) Хүн, мал, амьтны халдварт өвчин болон хөдөө аж ахуйн хортон шавж улсын хил давж тархах аюулын талаар цаг тухайд нь бие биедээ мэдээлнэ.
- **33 дугаар зүйлд** Хилийн зөрчил будилааныг зохицуулах зорилгоор хилийн бүрэн эрхт төлөөлөгчид буюу хилийн бүрэн эрхт төлөөлөгчийн даалгаснаар тэдний орлогч болон туслагч нар нь (з) ойн болон хээрийн түймэр улсын хил даван тархсан үед хамтарсан мөрдөн шалгалт явуулна.
- **35 дугаар зүйлд** Хилийн бүрэн эрхт төлөөлөгчид нь (в) улсын хилийн ойролцоо гарсан хүн, мал амьтдын гоц халдварт өвчин, түүнчлэн хөдөө аж ахуйн ба ойн хортон шавжийн их хэмжээтэй тархалт, ойн болон хээрийн түймэр, түүнчлэн үер бусад асуудлын талаар мэдээлэл солилцоно хэмээн тус гэрээнд талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлжээ.

Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон ОХУ-ын Дотоод хэргийн яам хоорондын хэлэлцээрийг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Улаанбаатар хотноо байгуулсан байна. Энэ хэлэлцээр нь гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журмыг сахиулах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах салбарт олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, талуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн байна.

Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулалттай үндэстэн дамжсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг олж тогтоох, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцсон байх бөгөөд үүнээс гадна, өмчийн эсрэг, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх практик үйл ажиллагаанд өндөр ач холбогдол өгсөн байна. Жишээ нь гэмт хэрэг үйлдэхээр бэлдэж буй эсхүл гэмт хэрэг үйлдсэн болон түүнд холбогдолтой хүмүүсийн талаар мэдээлэл солилцох, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах хүсэлтийг биелүүлэх, оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлах зэрэг эрүүгийн процессын тодорхой ажиллагааг харилцан гүйцэтгэхээр тохирсон байна.

Энэ хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон ОХУ-ын Дотоод хэргийн яам хооронд 2017-2020 онд хамтран ажиллах протоколыг 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдөр үйлдсэн байна.

Гурав. 2011 оны 5 дугаар сарын 31-ний өдөр “Увс нуурын хотгор” хил дамнасан дархан цаазтай газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулжээ.

Энэ хэлэлцээр нь Хүрээлэн буй орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын 1994 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хэлэлцээрийг хэрэгжүүлэх, ЮНЕСКО-ийн байгалийн өвд бүртгэгдсэн Увс нуурын сав газрын байгалийн иж бүрдлийг хамгаалах зорилготой байна.

Энэ хэлэлцээрийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хоёр улсын эрх бүхий байгууллагууд нь “Увс нуурын хотгор” хил дамнасан дархан газрын хил дотор ховор болон устаж үгүй болох аюулд өртөөд байгаа төрлийн амьтан, ургамлыг оролцуулсан байгалийн иж бүрдэл, объектыг хамгаалах; экологийн хууль тогтоомжийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох; сөрөг нөлөөний талаар харилцан мэдээлэх; дархан газрын нутгаар зэрлэг амьтад саадгүй нүүдэллэх нөхцөлийг хангах зэрэг хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Хүснэгт 7. Хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг байгуулж, хамтын ажиллагааг хөгжүүлэхээр хэлэлцэгдэж буй газрууд

| № | Хил дамнасан хамгаалалттай газар байгуулахаар хэлэлцэж буй газрууд | Хамрагдах улс | Хил дамнасан хамгаалалттай газар байгуулах талаар санал тавьж эхэлсэн он | Үйл ажиллагаа |
|---|--|-----------------|--|--|
| 1 | Амарын эх - Онон Балж, Сохонд | 2 Монгол-ОХУ | 1994 | Хамгаалалтын захиргаадын хүрээнд хамтын ажиллагааны төлөвлөгөөг 2002 оноос хойш тогтмол боловсруулан хэрэгжүүлж байна. |
| 2 | Хөвсгөлийн БЦГ - Тункинский БЦГ | 2 Монгол-ОХУ | 1993 | Хамгаалалтын захиргаадын хүрээнд уулзалт хийж, хамтран ажиллаж байна. |
| 3 | Сийлхэм БЦГ - Салюгем БНГ | 2 Монгол-ОХУ | 1995 | Хамгаалалтын захиргаадын хүрээнд уулзалт хийж, хамтран ажиллаж байна. |

Амарын эх буюу Онон Балжийн Байгалийн цогцолборт газар (БЦГ) болон Сохондын шим мандлын нөөц газруудыг хамруулан хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутаг байгуулахаар хоёр тал харилцан тохиролцсон боловч өнөөг хүртэл энэ гэрээнд гарын үсэг зурагдаагүй байна.

Хөвсгөл-Тункен болон Сийлхэм-Салюгемийн хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулахаар хоёр улсын холимог комиссын 5 дугаар хуралдаанаар дэмжсэн бөгөөд хурлын тэмдэглэлийн дагуу гэрээний зүйл заалтын талаар хоёр улс хамтын ажиллагааны гэрээний төслийг Гадаад харилцааны яаманд хүргүүлээд байна.

Дөрөв. Монгол-Оросын гаалийн байгууллагуудын хамтын ажиллагаа. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Монгол-Оросын гаалийн байгууллагууд олон чиглэлээр идэвхтэй хамтын ажиллагааг өрнүүлэн ажиллаж, жилээс жилд хоёр талт хамтын ажиллагаа улам өргөжин, хөгжиж ирсэн байна. Монгол-Оросын гаалийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа 1993-2017 онуудад байгуулсан Засгийн газар хоорондын болон байгууллага хоорондын хэлэлцээр, протокол, санамж бичиг, төлөвлөгөө зэрэг баримт бичгээр зохицуулагдаж байна.

Гаалийн асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын 1993 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр ОХУ-ын Сочи хотноо “Гаалийн хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх хүрээнд 2018-2019 онд хамтран ажиллах төлөвлөгөө, Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон ОХУ-ын Холбооны гаалийн алба хоорондын хамтран ажиллах төлөвлөгөөг баталсан байх бөгөөд 2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай хэрэгжүүлж байна. Энэхүү төлөвлөгөөнд “Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйл, түүний бүтээгдэхүүн (CITES-ын объект)-ийг хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх зэрэг гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хамтарсан төлөвлөгөөт үйл ажиллагааг Талууд хэрэгжүүлэхээр тусгажээ.

Ер нь Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон ОХУ-ын Дотоод хэргийн яамны идэвхтэй практик үйл ажиллагаа мөн манай хоёр улсын гаалийн байгууллагуудад нэвтэрч байгааг тэмдэглэх нь зүйтэй.



ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

2018 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 660 хуулиас 110 орчим хуульд хүрээлэн буй орчинтой холбоотой харилцааг зохицуулсан зүйл, заалтууд орсон байна. Эдгээр 110 орчим хуулиас зэрлэг амьтан, ургамалтай холбоотой харилцааг зохицуулсан 11 хууль, түүнтэй нийцүүлэн Монгол Улсын Засгийн газраас 28 хуульчилсан актыг батлан гаргаж, түүнийг даган мөрдөж байна. Улмаар амьтан, ургамал, тэдгээртэй холбогдох харилцааг зохицуулсан олон улсын 6 гэрээнд нэгдэн оржээ.

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ¹” гэж заасан нь хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ хоёр оронтой харилцах үндсэн зарчмыг тодорхойлсон байна.

Байгаль орчин, зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх нь манай улс төдийгүй, дэлхийн нийт улс орнууд, бүс нутгийн тулгамдсан асуудал болоод байна. Энэ талаар Монгол Улс нь ОХУ, БНХАУ-тай гурван талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинэ шатанд гаргахад онцгойлон анхаарч, хүчин чармайлт тавьсаар байна. Тухайлбал, Узбекистаны нийслэл Ташкент хотноо болсон Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын төрийн тэргүүнүүдийн гурван талт уулзалтын үеэр (2016 оны 6 дугаар сарын 23-ны өдөр) гурван улсыг холбосон “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрт Монгол, Орос, Хятадын хил дамнасан экологийн коридоруудыг байгуулах, зэрлэг ургамал болон амьтны аймаг, ус, намгархаг газартай холбогдох эрдэм шинжилгээний хайгуул, хяналт шинжилгээ хийж, зэрлэг амьтан, ургамал, нүүдлийн шувуудыг хамгаалах салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэхээр тусгасан нь энэ салбарт хөрш орнуудтай гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх стратегийн үндэс суурийг тавьжээ.

Улаанбаатар хотноо үзэглэсэн 1990 оны “БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр, 1994 онд Улаанбаатар хотод байгуулсан “Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах

¹ http://www.mfa.gov.mn/?page_id=25999// Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал/Монгол Улсын Их Хурлын тогтоол. Дугаар 10. 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр. Улаанбаатар хот

салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр” зэрэг байгаль орчин, зэрлэг ургамал, амьтныг хамгаалах чиглэлийн суурь хэлэлцээрүүд байгуулагдсан байна.

Эдгээр хэлэлцээрүүд нь Олон улсын гэрээний тухай Венийн конвенц, 2016 оны Олон Улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлд заасан олон улсын хоёр талт гэрээний хууль зүйн техникийн болон агуулгын стандарт, зарчмыг бүрэн хангасан чухал ач холбогдол бүхий баримт бичгүүд гэж үзэх үндэстэй байна.

Гэвч эдгээр баримт бичгийг Талууд хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй бараг 20 гаруй жил завсарласан нь туйлын харамсалтай. Тухайлбал, 2010 онд Улаанбаатар хотод байгуулсан Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ байгуулагдаж, Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хооронд хууль бусаар хил давуулан худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг 2018 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр Бээжин хотноо үзэглэж, 1993 онд Улаанбаатар хотноо байгуулсан Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, 2010 оны 6 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Засгийн газар хоорондын 1993 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн хоорондын протокол, 2011 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн хоорондын хэлэлцээр зэргийг дурдаж болохоор байгаа бөгөөд 1993 онд байгуулсан хэлэлцээрүүдийг 2010 оноос хэрэгжүүлэхээр ярилцаж эхэлсэн нь үүний тод жишээ болж байна.

2010 оноос өмнө ганц нэг салбарын уулзалтыг эс тооцвол ОХУ, БНХАУ-тай байгаль хамгаалах, зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх хамтын ажиллагааны орон зай орхигдсон гэж үзэж болохоор байна. Энэ нь нэг талаас үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй, тухайлбал хар тамхи, зэр зэвсэг, хүн худалдаалах, терроризм зэрэгтэй тэмцэх олон улсын чиг хандлага давамгайлсан, нөгөө талаас нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал зэрэг объектив субъектив хүчин зүйлс нөлөөлсөн байж болох талтай байна.

Мөн 1993-2010 онд автомашин, спирт, ноолуур, тарваганы арьс зэргийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг зонхилж байсан бол 2010-аад оноос алт, үнэт болон хагас үнэт чулуу, хар тамхи, мансууруулах бодис зэргийг их хэмжээгээр хил давуулан худалдах, хилийн цаана тэдгээрийн эрэлт хэрэгцээ нэмэгдэх болсон нь байгаль орчин, зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх асуудал түр орхигдож, түүний өсөх нэг шалтгаан болсон байж болох юм.

Судалгаанаас үзэхэд, зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн ихэнх хувь нь БНХАУ-тай хил залгаа аймгуудад илэрч байгаа нь сонирхол татаж байна. ОХУ-тай хил залгаа аймгуудад энэ төрлийн гэмт хэрэг нутгийн гүнд үйлдэгдэж, БНХАУ-ын хил дээр илэрч байна. ОХУ-ын хил дээр энэ төрлийн гэмт хэрэг цөөн илэрч байгаа нь нэгдүгээрт, хилийн хамгаалалтын цоорхой их, ой хөвч шууд залгасан, нөгөө талаас ОХУ-ын хил залгаа нутгууд ховор амьтан, ургамал ихтэй учраас эрэлт хэрэгцээ бага, түүнчлэн ОХУ, БНХАУ нь шууд хиллэдэг учир гэмт этгээдүүд гуравдагч орноор дамжуулан зэрлэг амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд эрсдэл ихтэй, сонирхол бага зэргээс үүдэлтэй байж болох талтай.

1990 оны “БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, 1994 оны “Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр” зэрэг тулгуур хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын зөвшөөрлөөр түүний яам, агентлагуудын хооронд байгуулсан салбарын гэрээ, хөтөлбөр, хамтын ажиллагааны төлөвлөгөө чухал үүрэгтэй.

Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон ОХУ-ын Дотоод хэргийн яам хоорондын хэлэлцээрийг 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Улаанбаатар хотод байгуулж, түүний хүрээнд зохион байгуулалттай үндэстэн дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг олж тогтоох, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцсоны дотор өмчийн эсрэг, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх практик үйл ажиллагаанд өндөр ач холбогдол өгсөн байна. Мөн гэмт хэрэг үйлдэхээр бэлдэж буй эсхүл гэмт хэрэг үйлдсэн болон түүнд холбогдолтой хүмүүсийн талаар мэдээлэл солилцох, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах хүсэлтийг биелүүлэх, оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлах зэрэг эрүүгийн процессын тодорхой ажиллагааг харилцан гүйцэтгэхээр тохирсон байна.

2017 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо “Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Эрүүгийн цагдаагийн алба болон БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхим хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт хоёр тал гарын үсэг зурсан байх бөгөөд энэ нь тодорхой төрлийн зарим гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох, туршлага солилцох агуулгатай байна.

Товч дүгнэхэд, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон ОХУ-ын Дотоод хэргийн яамны хамтын ажиллагаа шууд процессын хэлбэрээр хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой байхад Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам хоорондын хамтын ажиллагаа зөвхөн мэдээлэл солилцох, туршлага судлах, сургалт зохион байгуулах төдийгөөр хязгаарлагдаж байна.

Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газар болон БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын Гаалийн цагдаагийн газар 2017 оны ... дугаар сарын 16 өдөр Улаанбаатар хотноо “Гаалийн асуудлаар 2018-2019 онд хамтран ажиллах төлөвлөгөөг” батлан хэрэгжүүлж байна. Тус төлөвлөгөөний дагуу Талууд хил дамнасан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр хамтарсан ажиллагаа зохион байгуулах, тодорхой нэг төрлийн хэрэг зөрчилтэй тэмцэх чиглэлээр талуудын хил залгаа боомтууд дээр нэгдсэн удирдлага, төлөвлөгөө бүхий хамтарсан ажиллагааг 2019 оноос зохион байгуулахаар тус тус заасан нь байгаль орчин, зэрлэг ургамал, амьтны аймгийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагааны нэг шинэ хуудас нээсэн хэрэг болж байна. Энэ талаараа дотоод хэргийн байгууллагуудаас алхам урагшилсан хэрэг болсон байна.

2010 онд Улаанбаатар хотноо байгуулсан Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээний 24 дүгээр зүйлд “Талууд хил зөрчих, хил орчмын нутагт хууль бусаар оршин суух, хөдөлмөр эрхлэх, контрабанд хийх, хар тамхи, мансууруулах бодис, хориотой барааг худалдах, тээвэрлэх зэрэг хил дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтран тэмцэхэд чиглэсэн хамтын ажиллагааг бэхжүүлнэ. Талууд болон Талуудын эрх бүхий байгууллага энэ талаар холбогдох хэлэлцээр байгуулж болно” хэмээн тус тус тусгажээ.

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол-Оросын гэрээ нь хөтөлбөрийн шинж давамгайлсан дэлгэрэнгүй, Монгол-Хятадын гэрээ нь суурь зарчим, ерөнхий чиг хандлагыг тодорхойлсон тунхгийн шинж давамгайлсан онцлог ажиглагдаж байна.

ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газар болон холбогдох яам, агентлагуудад байгаль орчныг хамгаалах, зэрлэг ургамал, амьтан, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний хил дамнасан хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэмцэх, хамтын ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Монгол Улс нь 1998 оны “Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тухай Аархусын конвенц”-д нэгдэн орох шаардлагатай байна. Учир нь иргэд байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шаардах эрхээ мэдэхгүйгээс байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүд өөрсдийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөхгүй байх, мөн иргэдийн байгаль орчны хууль тогтоомжийн мэдлэг хомс байгаагийн улмаас гэмт хэргийн субъект болох хандлага шүүхээр шийдвэрлэгдэж буй болон ЦЕГ, ГЕГ, МХЕГ-аас илрүүлсэн хэргийн материалуудаас харагдаж байна.
2. Монгол Улсын Засгийн газрын яам, агентлагуудаас байгаль орчин, зэрлэг амьтан, ургамлыг хамгаалах, түүний эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх таатай орчин бүрдэж буй өнөө үед хөрш хоёр орны адил түвшний байгууллагуудтай энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамтран тэмцэх хамтын ажиллагааг өргөжүүлж, холбогдох гэрээ хэлэлцээр байгуулж, хөтөлбөр төсөл хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна. Хамтын ажиллагааны төлөвлөгөө нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний бус акт учраас энэ практикаас татгалзах шаардлагатай. Харин хөрш орны яам, агентлагуудын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, тэдгээрт тусгагдсан санхүүгийн эх үүсвэрийн үндсэн дээр тодорхой төлөвлөгөө гарган хэрэгжүүлж болох юм.
3. Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Хил хамгаалах ерөнхий газар нь БНХАУ, ОХУ-ын хил хамгаалах байгууллагуудтай байгуулсан үндсэн гэрээнд заасан боломжуудаа бүрэн ашиглаж Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зэрлэг амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний хууль бус худалдаатай хамтран тэмцэх, таслан зогсоох талаар дэд гэрээг хөрш орны адил түвшний албад, хилийн төлөөлөгчидтэй байгуулж ажиллахыг зөвлөж байна.

Хилийн төлөөлөгчид хэрэг бүртгэх эрхтэй улсын байцаагчийн эрхийг хууль тогтоомжид заасны дагуу олгох хэрэгтэй юм.

4. Монгол Улсын Засгийн газар, холбогдох яам, агентлагууд нь БНХАУ, ОХУ-ын адил төстэй байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийг шинэчлэн байгуулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохих шат түвшинд байгуулж, хамтын ажиллагааны практик алхмуудыг хийж эхлэх нь зүйтэй.

САНАЛ

Олон улсын эрх зүйн баримт бичгүүд, хоёр болон гурван талт гэрээ, хэлэлцээрүүд, УИХ-ын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан 2007-2021 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын стратегийн зорилтыг шийдвэрлэх, зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд цагдаа, хил, тагнуул, гаалийн болон мэргэжлийн хяналтын байгууллагууд дангаараа эсхүл тэдний хамтын ажиллагаагаар хязгаарлалгүй, мөн орон нутгийн төрийн болон өөрөө удирдах ёсны байгууллага, олон нийтийн байгууллага, ард иргэдийн өргөн дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Үүний тулд;

1. Байгаль орчин, зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх, ерөнхий арга хэмжээний хүрээнд олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, улмаар зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах журмын эсрэг гэмт явдлыг өөгшүүлж байгаа худалдан авах сувгийг хаах, гэмт этгээдүүдийг “орлологүй болгох”
2. “Байгаль орчин, зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан үе шаттайгаар авч хэрэгжүүлэх
3. Хөрш зэргэлдээ орнуудын манай улстай хиллэж байгаа бүс нутгийн болон хил орчмын аймаг, сум, орон нутгийн онцлогт тохирсон урьдчилан сэргийлэх арга хэмжээг төр, захиргааны болон олон нийтийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах

4. Хууль сахиулах (цагдаа, хил, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээ, гадаадын харьяатын байгууллага г.м) болон байгаль орчны байгууллагууд, мөн гааль, тагнуул, мэргэжлийн хяналт, хорио цээрийн албууд нягт уялдаа холбоотой ажиллах, энэ ажилд сум, дүүрэг, төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хувь хүмүүсийн оролцоо, хяналтыг сайжруулах, урамшууллын тогтолцоог бий болгох
5. Хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй бусад орны дэвшилтэт шинэ арга, инновац, технологид суралцах, гэмт хэрэг үйлдэж буй сэжигтэй этгээдүүдийн тухай мэдээллүүдийг цуглуулж, задлан шинжлэх, боловсруулалт хийх, мэдээлэл солилцохын тулд орчин үеийн дэвшилтэд техник, технологийг өргөн ашиглах, нэгдсэн мэдээллийн сантай болох
6. Хөрш зэргэлдээ орнуудын болон олон улсын хууль хяналтын байгууллагуудтай зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах, харилцан мэдээлэл солилцох, хамтарч ажиллах, боловсон хүчнээ бэлтгэх
7. Хил, гааль болон мэргэжлийн хяналтын ажилтнуудын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, шинжлэх ухаан техникийн шинэ дэвшилтэд технологийг тэдэнд зааж сургах, мөн ард иргэдэд холбогдох хууль тогтоомжийг танилцуулах, урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх, гааль, хил хамгаалах байгууллагын ажилтнуудад зориулан “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийн сургалт зохион байгуулах, дэмжлэг тусалцаа үзүүлэх
8. Тусгай тоног хэрэгслийг ашиглаж, техник, технологийн хангамжийг сайжруулах замаар гаалийн хяналтыг сайжруулж, гэмт хэрэг илрүүлэхэд камер, рентген, нохой, нисэгчгүй жижиг оврын онгоц, нисэх аппарат ашиглах
9. Хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт шалгалтын явцад хураагдсан эд зүйлс, эрхтэн, бүтээгдэхүүнийг хадгалах чанартай, зориулалтын тусгай агуулах байгуулах
10. Хураагдсан амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтнийг түргэн шуурхай таних, тодорхойлох чадвар бүхий мэргэжлийн лаборатори байгуулах

11. Хил, гаалийн хамгаалалтад орчин үеийн шинжлэх ухааны ололт, дэвшилтэт хурууны хээ бүртгэгч, виртуал, дижитал болон сүлжээний технологи, хэт ягаан туяаны хөдөлгөөн мэдрэгчтэй камер зэргийг ашиглах, хурууны хээний цахим сан бүрдүүлэх
12. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам хооронд 2011 онд байгуулсан хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийн Хамтын ажиллагааны чиглэл гэсэн 3 дугаар зүйлд **“Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, ялангуяа зэрлэг амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүнийг хууль бусаар тээвэрлэх, худалдаалах хил дамнасан гэмт хэрэг, зөрчилтэй хамтран тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх”, түүнчлэн “Хил дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр талуудын хил залгаа боомтууд дээр тодорхой төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу нэгдсэн удирдлага, төлөвлөгөө бүхий хамтарсан ажиллагаа зохион байгуулах”** гэж нэмж болохоор байна.



АШИГЛАСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, АЖЛЫН ТАЙЛАН

Нэг. Хууль тогтоомж

- 1.1. Монгол Улсын Үндсэн хууль (1992). Улаанбаатар
- 1.2. Амьтны тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2012). Улаанбаатар
- 1.3. Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалт тухай хууль (2002). Улаанбаатар
- 1.4. Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995). Улаанбаатар
- 1.5. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ (2012). Улаанбаатар
- 1.6. Байгалийн ургамлын тухай хууль (1995). Улаанбаатар
- 1.7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2012). Улаанбаатар
- 1.8. Гаалийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2008). Улаанбаатар
- 1.9. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002). Улаанбаатар
- 1.10. Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2017). Улаанбаатар
- 1.11. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ (2015). Улаанбаатар

Хоёр. Олон улсын гэрээ, конвенц

- 2.1. Биологийн олон янз байдлын тухай конвенц (1993) /Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 9 дүгээр тусгай дугаарын албан ёсны эх сурвалжаас авав/
- 2.2. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (1999)
- 2.3. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (1996)
- 2.4. Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (1997)
- 2.5. Халим агнуурыг зохицуулах тухай олон улсын конвенц (2002)
- 2.6. Биологийн төрөл зүйлийн тухай конвенцийн биоаюулгүй байдлын тухай Картагены протокол (2003)
- 2.7. Ургамал хамгааллын тухай Ромын конвенц (2009)
- 2.8. Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тухай конвенц (1998)

Гурав. Монгол Улсын бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүд

- 3.1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010). Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол. Улаанбаатар
- 3.2. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (2016). Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол. Улаанбаатар
- 3.3. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (1997). Улсын Их Хурлын 1997 оны 106 дугаар тогтоол. Улаанбаатар
- 3.4. Ногоон хөгжлийн бодлого (2014). Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоол. Улаанбаатар
- 3.5. Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр (2011). Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 277 дугаар тогтоол. Улаанбаатар
- 3.6. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015). Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоол. Улаанбаатар
- 3.7. Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр (2002). Засгийн газрын 2002 оны 105 дугаар тогтоол. Улаанбаатар

Дөрөв. Судалгааны ажил, тайлан

- 4.1. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар (2008). “Мэдээлэл, сургалт, сурталчилгааг оновчтой хүргэх замаар ан амьтдын гаралтай эд зүйлсийн хууль бус худалдааг бууруулах нь” тайлан (Байгаль орчны шинэчлэл II). Улаанбаатар
- 4.2. ЦЕГ-ын МДШШУА (2018). Монгол Улсад 2013-2017 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт. Улаанбаатар
- 4.3. Эрдэнэбаяр, М. (2015). Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн байцаах, урьдчилан сэргийлэх онол, арга зүйн асуудал (Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан диссертаци). Улаанбаатар

Тав. Цахим эх сурвалж

- 5.1. <http://www.legalinfo.mn>
- 5.2. <https://www.mne.mn>
- 5.3. <http://police.gov.mn>
- 5.4. <https://mojha.gov.mn>
- 5.5. <http://bpo.gov.mn>
- 5.6. <https://www.eic.mn>

ХАВСРАЛТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ 1990 ОНЫ 5 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДРИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛ (ТӨСӨЛ)

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар /цаашид Талууд гэх/,

Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай 1994 оны гэрээ, “Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай 1994 оны хамтарсан тунхаглал”-ын үзэл санааг үндэс болгож,

Гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 2011 оны хэлэлцээр, Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1949-2012 онд байгуулсан хоёр талт гэрээний үйлчлэлийн талаарх Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2014 оны протоколын холбогдох заалтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого, БНХАУ-ын экологийн соёл иргэншлийн бүтээн байгуулалтын хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд,

БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай 1990 оны хэлэлцээр нь Олон Улсын гэрээний тухай Венийн конвенцийн зарчим, түвшин, агуулга хэлбэрт бүрэн нийцэж, олон улсын эрх зүйн ач холбогдол хэвээр байгааг анхаарч,

Талууд байгаль орчныг хамгаалах салбарт засгийн газар, түүний яам, байгууллагуудын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагаа өргөжиж байгааг сайшаан тэмдэглэж,

БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай 1990 оны хэлэлцээрийн Аравдугаар зүйлийг иш үндэс болгон уг хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулахаар харилцан тохиролцов.

Нэгдүгээр зүйл

Талууд Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд зааснаар Хэлэлцээрийн “Бүгд Найрамдах Монгол Улс” гэснийг “Монгол Улс” гэж өөрчлөх;

Хоёрдугаар зүйл

Хэлэлцээрийн Гуравдугаар зүйлд: “ - Талууд хоёр талын хуулийн байгууллагууд, хууль сахиулах байгууллагууд, түүний дотор хил хамгаалах, гааль, цагдаа, авлигатай тэмцэх зэрэг байгууллага хоорондын өндөр түвшний харилцаа, хамтын ажиллагааны механизмыг хөгжүүлэн бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллах”;

“ - Талууд байгаль орчин, ялангуяа зэрлэг амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүнийг хилээр хууль бусаар тээвэрлэх, худалдаалах зэрэг хил дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг, зөрчилтэй хамтран тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх талаар хуулийн болон байгаль орчныг хамгаалах, цагдаа, хил, гааль, хилийн хяналтын бусад байгууллагуудын хамтын ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгох, хамтарч ажиллах” гэж нэмэх.

Мөн зүйлд “Хил дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр талуудын хил залгаа боомтууд дээр тодорхой төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу нэгдсэн удирдлага, төлөвлөгөө бүхий хамтарсан ажиллагаа зохион байгуулах” гэж нэмэх.

Дөрөвдүгээр зүйл

Энэхүү нэмэлт протокол нь Үндсэн гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

Тавдугаар зүйл

Энэхүү протоколыг хотноо 2020 оны сарын ... өдөр Монгол болон Хятад хэл дээр хоёр хувь үйлдэв.

Талуудын гарын үсэг